

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн 3-р үе шатны тайлан

ГАРЧИГ

1. Төслийн 3-р үе шатны зорилго, хийсэн ажлын талаар	3
1.1. Мониторингид дүн шинжилгээ хийх арга зүй, аргачлал	3
1.2. Сонгож авсан засаг захиргааны нэгжүүдэд явуулсан мониторинг, дүн шинжилгээ	4
1.2.1. Хот, суурины газар ашиглалт	4-10
1.2.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн газар ашиглалт	10-15
1.2.3. Бэлчээрийн газар ашиглалт	15-22
1.2.4. Уул уурхайн газар ашиглалт	23-25
1.2.5. Газар тариалангийн газар ашиглалт	26-29
1.2.6. Хууль эрх зүйн дүгнэлт	29-31
2. Хэвлэл мэдээллийн мониторинг, дүн шинжилгээ	31
2.1. Төслийн хүрээнд хийж буй ажлыг олон нийтийн дунд сурталчлах талаар	31-32
3. Төслийн хэрэгжилтийн явцад зохион байгуулсан семинарын талаар	32-33
3.1. Семинарын илтгэлүүдээр тайлан бичих	
4. Экспертүүдийн дүн шинжилгээнд өгөх ерөнхий дүгнэлт	34
4.1. Газар ашиглалтын гол чиглэлүүдээр гаргасан дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал	
4.1.1. Тусгай хамгаалалттай газар нутаг	34-35
4.1.2. ХАА-н газар	35-37
4.1.3. Хотын газар	38
5. Эрдэм шинжилгээ - практикийн бага хурал зохион байгуулсан талаар	39-40
5.1. Илтгэлүүдээр эмхтгэл, зөвлөмж бэлтгэж гаргах	

5.2. Төслийн явц, үр дүнгийн талаар сонинд нүүр гаргах

6. Хавсралт

6.1. Газар ашиглалтын чиглэлээр боловсруулсан “Case study”	40
6.1.1. ТХГН-ийн газар ашиглалтанд хийсэн “Case study”	40-45
6.1.2. Хотын газар ашиглалтанд хийсэн “Case study”	45-49
6.1.3. ТХГН болон хот суурины чиглэлээр хийсэн “Case study”-д хамрагдсан объектын газар ашиглалтын зөрчлүүд	49-54
6.1.4. “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн хүрээнд хийгдсэн мониторингийн дүнтэй холбогдуулан гаргасан дүгнэлт, санал	54-62

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн 3-р үе шатны тайлан

Нэг. Төслийн гуравдугаар үе шатны зорилго, хийсэн ажлын талаар

Зорилго: Гурав дахь үе шатны гол зорилго нь газрын шинэтгэлтэй холбогдон гарсан хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх хүрээнд газар ашиглалтын гол хэлбэрүүдээр хийгдсэн мониторингийн үйл ажиллагаанд мэргэжлийн экспертүүдээр дүн шинжилгээ хийлгэж, ТХГН, бэлчээр, ашигт малтмалын болон тариалангийн мөн хот суурины газар ашиглалтад гарч буй эерэг, сөрөг үр дагаврууд, зөрчил маргаанд олон нийтийн зүгээс өгч буй санал бодолд дүн шинжилгээ хийж, цаашид газрын шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлох явдал байлаа.

Мөн газрын талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад зөрчигдөж байгаа хуулийн зүйл, заалтуудыг олж тогтоон дүн шинжилгээ хийх, улмаар цаашид гарч болзошгүй алдаа, дутагдлыг урьдчилан анхааруулж, ойлгуулах замаар газрын шинэтгэлийг үнэлэх нэг үзүүлэлт болсон нийгмийн тэгш байдлыг хангахад чиглэсэн, иргэдийнхээ эрх ашгийн төлөө үйлчилдэг механизмыг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилготой юм.

Хийсэн ажлын талаар

1.1. Мониторингид дүн шинжилгээ хийх арга зүй, аргачлал

Энэхүү төслийн аргачлалын хүрээнд судалгаа, мониторингийн чиглэлээр сонгогдсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд явуулсан төслийн ажилтнуудын судалгааны материалд үндэслэн, мэргэжлийн экспертүүдийн зүгээс холбогдох дүн шинжилгээг тодорхой тоон болон чанарын мэдээллийг ашиглан хийв.

Дүн шинжилгээ хийхдээ арга зүйн дараахь гол зарчмуудыг мөрдөн ажиллав.

- Тухайн газар нутгийн онцлог, хууль хэрэгжих бодит нөхцөл байдал
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, зөрчил
- Хуулийн хэрэгжилтэнд олон нийтийн оролцоо, хяналт тавих боломж
- Газрын харилцаатай холбогдсон асуудлыг шийдэхэд ялангуяа хүний эрхийг хангахад төрийн байгууллага, эрх мэдэл бүхий түшмэдийн зүгээс хир зэрэг анхаарч байгаа зэргийг анхаарсан болно.

Мэргэжлийн экспертүүдийн дүн шинжилгээг газрын харилцааны гол чиглэлүүд болох газар тариалан, бэлчээр, хадлан, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт, ашигт малтмалын орд газрын ашиглалт, нөхөн сэргээлт, хөдөө орон нутаг дахь хот, суурины болон Улаанбаатар хот, түүний ногоон бүс, алслагдсан дүүргүүдэд хуулиудын хэрэгжилтийн байдал түүний үр дүн, газрын шинэтгэлийн асуудлаар хэвлэлд гарсан материал болон олон нийтийн санал асуулгын дүнг нэгтгэн дүгнэх зэрэг аргаар гүйцэтгэсэн болно.

Дээрхи чиглэлээр хийгдсэн ажлын дүгнэлтийг бодитой хийхийн тулд мэргэжлийн чиглэлээр олон жил ажилласан ажлын дадлага туршлагатай экспертүүдийг сонгон ажиллуулж, мэргэжлийн экспертүүд болон төслийн удирдлагын саналыг тусган, зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталгаажуулсан болно.

1.2. Сонгож авсан засаг захиргааны нэгжүүдэд явуулсан мониторинг, дүн шинжилгээ

- 1.2.1. Хот, суурины газар ашиглалт
- 1.2.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн газар ашиглалт
- 1.2.3. Бэлчээрийн газар ашиглалт
- 1.2.4. Уул уурхайн газар ашиглалт
- 1.2.5. Газар тариалангийн газар ашиглалт
- 1.2.6. Хууль эрх зүйн дүгнэлт

1.2.1. Хот, суурины газар ашиглалт

Газрын шинэтгэлийн мониторингийн хүрээнд хот суурин газарт газрын хууль, тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаа талаар олон нийтийн санаа бодол ямар байгааг хот суурины барилгажсан хэсэг болоод хот орчмын ногоон бүс, алслагдсан дүүргүүдэд амьдардаг, нийгмийн янз бүрийн төлөөлөл болж чадах,

нас, боловсрол, амьдрах орчин нөхцлөөрөө харилцан адилгүй иргэдийг оролцуулж судалсан болно.

Хот суурины газар олголтонд учирч буй үндсэн бэрхшээлүүдийг дараах байдлаар төрөлжүүлэн авч үзэв. Үүнд:

- Газар авахын тулд хаана хандахаа мэдэхгүй олон удаа явсан
- Мэдээлэл ил тод биш, хаана газар авахаа мэдэхгүй байсан
- Газрын зөвшөөрөл олгох ажил олон шат дамжлагатай байна
- Газар авахад танил тал, хээл хахууль хардаг зэрэг бэрхшээлийг Улаанбаатар хотоос оролцогсдын 44% нь дурджээ.

Ийм байдал хот орчмын зусланд амьдардаг хүмүүсээс авсан судалгаанд ч мөн адил байна.

Үүнээс үзвэл хот, сууринд газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай мэдээлэл хомс, ил тод бус, Нийслэл дүүрэг, Аймаг ба аймгийн төв, сумын газрын албаны бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хувиарлалт хангалтгүй, удирдлагын оновчтой тогтолцоо бүрдээгүй, газрын хуулийн талаархи иргэдийн мэдлэг бага байгаа нь харагдаж байна.

Мөн тухайн иргэн газар авахад учирдаг хүндрэл, чирэгдлийн талаар Улаанбаатар хотоос оролцогсдын 24-31% нь Засаг даргын шийдвэр гаргуулахад, 14-15% нь техникийн нөхцөл тогтоолгоход, 11-20% нь газрын гэрээ гэрчилгээ авах шатанд хамгийн их чирэгдэлтэй гэж хариулжээ. Харин өргөдлийг шийдвэрлэхэд хотод хүндрэлтэй /9-11%/, хөдөөгийн хотуудад харьцангуй хялбар /2%/ байна. Энэ нь Нийслэл ба аймгийн төв хотуудын газрын албаны ачаалал харилцан адилгүй байгаа бөгөөд захирамж шийдвэр гаргуулах нь хөдөө, хот ялгаагүй удаашралтай, техникийн нөхцөл тогтоолгох асуудал хот, хөдөө аль алинд нь хүндрэлтэй байгааг харуулж байна. Мөн Газрын харилцааны удирдлагын тогтолцоо буруу, ялангуяа нийслэл, дүүрэг, аймаг, сумын Засаг даргын эрх хэмжээг адил тогтоосноос тэдний гаргасан шийдвэр давхцаж, бие биедээ саад төвөг учруулах нөхцлийг бүрдүүлж байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

Мөн газар олгох ажил газар зохион байгуулалтын тодорхой төлөвлөгөөгүй хийгддэгийн улмаас ялангуяа хамгийн эрэлт хэрэгцээтэй хот, суурины газарт байршлын схем хийж, техникийн нөхцөл тогтооход хэтэрхий олон байгууллага оролцож, хугацаа сунжрах нөхцөл бүрддэг ажээ. Жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг чанартай, шаардлагын хэмжээнд хийдэг бол ийм асуудал үүсэхгүй юм. Газар авахыг хүссэн иргэд, албан

байгууллага, аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл авахын тулд олон хүнд хандаж гарын үсэг цуглуулдаг болохоор ажлаа түргэвчлэх үүднээс танил тал харах явдал жирийн үзэгдэл болж хувираад байна.

Харин хот, дүүргийн газрын албаны удирдлагын ажил удаашралтай, чирэгдэлтэй явагдаж байгаад хүний хүчин зүйл хэрхэн нөлөөлж болохыг судлахад нийт оролцогчдын 8-23 хувь нь захирамж, шийдвэр гаргадаг эрх бүхий хүмүүс, 7-19 хувь нь хот байгуулалтын мэргэжилтнүүдийг ямар нэгэн хэмжээгээр хахуульд өртөмтгий гэж үзсэн нь газар авах асуудлыг шийдвэрлүүлэхэд гардаг гол хүндрэлүүдтэй нягт холбоотой байгааг баталж байна. Хот байгуулалтын мэргэжлийн хүмүүс болон захирамж шийдвэр гаргагч албан тушаалтнуудын эрх мэдэл хот суурин газарт давамгайлж, газрын сангийн удирдлагад буюу газрын харилцаанд сөргөөр нөлөөлж байна. Харин оролцогчдын 7 % нь газрын албаны мэргэжилтнүүд олон удаа явуулж, чирэгдүүлдэг гэсэн нь газрын эрхийг баталгаажуулахад тус албаны мэргэжилтнүүд хөшүүн хойрго ажиллаж буйн нотолгоо юм.

УБ хотын газар олголтын байдлаас харвал: өргөдлийг Газрын алба авч, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагад шилжүүлдэг бөгөөд энд барилгын байршил, техникийн нөхцөл тогтоолгох гэж хугацаа сунжирч, удааширдаг тул танил тал, хурдан түргэн шийдвэрлүүлэх арга зам хайж эхэлдэгээс архитекторч бол тухайн ажлын байранд хамгийн чухал хүн болдог байна. Техникийн санал зөвшөөрөгдөвч, байршил тогтоолгох захирамж, шийдвэр гаргахад хугацаа сунжирч хэдэн жилээр ч хүлээх, тэр ч бүү хэл өнөөдөр Газрын тухай хуучин хууль үйлчилж байхад бүх нөхцлөө тогтоолгоод, Засаг даргын захирамж нь гарахгүй байсаар шинэ хуультай золгосон Улаанбаатар хотын 300-аад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх ашиг хохирсон байна. Дүгнэлт, үндэслэл нь бүгд гарсан байхад Засаг дарга шийдвэрээ гаргахгүй байгаа нь тухайн мэргэжлийн комиссын дүгнэлттэй санал нийлэхгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна. Үүнээс харвал шийдвэр гаргагч субъектийн эрх дарх ямар их нөлөөтэй байгаа нь харагдах бөгөөд тэдэнд шийдвэр гаргаагүйн төлөө хүлээлгэх хариуцлага өнөөдөр үгүйлэгдэж байна.

Хот, суурин газарт нийт судалгаанд оролцогчдын 69-87 хувь нь хашааны газартай, 10-20 хувь нь худалдаа үйлчилгээний зориулалтаар газар ашигладаг, 3-14 хувь нь газаргүй гэж хариулсанаас үзэхэд дийлэнхи нь ахуйн зориулалтаар газар ашиглаж байгааг харуулж байна. Мөн Улаанбаатар хотын судалгаанд

оролцогчдын 20 хувь нь худалдаа үйлчилгээний зориулалтаар газар ашиглаж байхад, хөдөөд энэ тоо 2 дахин бага байна. Харин газаргүй иргэд хотод 14%, хөдөөд дөнгөж 3 хувь байгаа нь нийслэлд газрын хэрэгцээ өндөр байгааг илтгэж буй үзүүлэлт юм.

Алслагдсан дүүргүүдээс Багануур, Багахангай дүүрэг, Гацуурт тосгоныг сонгон судалгаанд хамруулжээ. Гацууртаас бусад нь нийслэлээс алслагдсан засаг захиргааны бие даасан тогтолцоотой, газрын харилцааг бие даан явуулдаг нэгжүүд бөгөөд харин Гачуурт тосгон нь Нийслэлийн БЗД-ийн 20-р хороонд харъяалагддаг, газрын харилцааг бие даан явуулах эрхгүй нэгж юм.

Гацуурт тосгоны хувьд газар өмчлөлийн ажил эхлээгүй байгаа нь холбогдох байгууллагууд газар өмчлөх асуудлыг шийдвэрлэж өгөхгүй удааж чирэгдүүлж байгааг харуулж байна. Энэ нь дүүргийн газрын албанаас зохион байгуулж байгаа ажил алслагдсан дүүрэгт хангалтгүй хүрч буйн жишээ гэж үзэхэд хүргэж байна.

Багахангай дүүрэг нь хамгийн бага нутаг дэвсгэр, хүн амтай засаг захиргааны үндсэн нэгж бөгөөд эндхийн иргэдийн дийлэнхи нь газраа өмчлөх гэрчилгээ авсан нь газрын эрэлт хэрэгцээ их байгаатай холбоотой, мөн газрын алба нь сайн ажилладгийг харуулж байна. Харин иргэд газраа эдийн засгийн эргэлтэнд оруулаагүй, энэ талаар цаашид тодорхой ахиц гарахгүй гэж үзэж байгаа нь иргэдэд сурталчилгааг хүргэж, оновчтой хэлбэрээр зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Иргэд газрынхаа асуудлыг хэнээр, ямар хугацааны дотор шийдвэрлүүлэв гэсэн асуултанд УБ хотод 3 сар ба 1 жилээс дээш хугацаагаар хүлээгдэж байхад, аймгийн төв хотод 0.5-3 сарын дотор, харин алслагдсан дүүрэг Багахангайд 1-3 сарын дотор, Багануурт 3-6 сарын дотор, Гачуурт тосгонд хугацаа нилээд сунжирч 6 сараас 1 жилийн дотор шийдүүлсэн байна.

Багахангайн оролцогчдын олонхи нь газар авахад бэрхшээлгүй гэсэн байхад Багануурт газрын албанаас асуудал боловсруулах үйл ажиллагаа сунжирдаг, Гачууртад бичиг баримт бүрдүүлж, гэрчилгээ авах шатанд хүндрэлтэй гэж үзсэн нь газрын харилцааны асуудлыг Баянзүрх дүүрэг шийддэгээс төрийн үйлчилгээ иргэдээс холдсонтой холбоотой юм.

Газрын зөвшөөрлийг голдуу сум, дүүргийн засаг даргаар шийдүүлсэн байгаа нь судалгаанд ихэвчлэн гэр хорооллын оршин суугчид хамрагдсантай холбоотой байна. Гэтэл 10 орчим хувь нь газрын харилцааны талаар шийдвэр гаргах эрх мэдэлгүй хороо, багийн засаг даргаар шийдүүлсэн нь газрын

харилцаанд эдгээр албан тушаалтнууд ямар нэг хэмжээгээр хууль зөрчин оролцож байгаагийн баримт юм.

Хот орчмын зуслангийн газрын ашиглалтын талаар санал асуулгад оролцогсдын 54 хувь нь газар эзэмших гэрчилгээ авсан буюу авах гэж байгаа, 12 хувь нь өмчлөх эрхийн гэрчилгээгээ авсан гэж хариулжээ. Гэтэл УБ хот нь 2003 оны 5-р сараас гэр хорооллын хашааны газрыг өмчлүүлж эхэлсэн бөгөөд зуслангийн газрыг өмчлөх ажил нэгдсэн журмаар эхлээгүй байхад судалгаанд оролцогсдын 10 гаруй хувь нь танил талаа ашиглан өмчилж авсан байж болзошгүй байна. Энэ нь Улаанбаатар хотод газрын асуудал нэгдсэн бодлогогүй явагдаж байгаагийн нэг тодорхой жишээ гэж үзэж болох юм.

Монгол Улсад газар өмчлөх үйл ажиллагаа эхлээд жил хагас боллоо. Газар өмчлөл нь төрөөс ард иргэдээ өмчтэй болгож, амьдрал ахуйг нь тэтгэх, эдийн засгийн хувьд бэхжүүлэх үндсэн зорилготой юм. Газар өмчлөлийн талаарх иргэдийн санаа бодлыг судлахад 34 - 54 хувь нь иргэнд өмчлөх, 34 - 47 хувь нь өрхөд, 6-15 хувь нь газар өмчлөх нь ерөөсөө буруу гэж үзсэн байна.

2003 оны 5 сараас эхэлсэн газар өмчлөлийн ажлын хүрээнд иргэдийн газар өмчлөл Улаанбаатар хотод 62%, Дорнод аймгийн Хэрлэн /Чойбалсан хот/ суманд 47% -тай явагдсан байна.

Харин иргэд, газрын шинэтгэлийг хүлээн авч, өмчийн газраа эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар хариулахдаа дийлэнхи нь буюу хотын иргэдийн 55%, хөдөөгийн иргэдийн 28 хувь нь хувьчилж авсан газар нь ямар нэгэн давуу тал байхгүй, цаашид байнга оршин суух зорилготой байгаа бол Улаанбаатар хотынхны 15-21 % хувь нь зам, автобусны буудал, үйлчилгээнд ойр гэж үзсэн ба хотынхны 1%, Хэрлэн сумынхны 4 % нь ирээдүйн хийгдэх том бүтээн байгуулалтанд ойр тул газрын үнэ өснө гэж найдаж байгаа юм байна.

Зуслангийн оршин суугчдын 23 хувь нь “Ойн тухай хууль” зөрчин ой модон дотор эзэмшил газартай, одоогоор хувьчлагдсан газрууд эдийн засгийн ашиг багатай зөвхөн тэдний оршин суух хэрэгцээг хангаж байгаа боловч хотын иргэдийн бараг 1/4 нь дэд бүтцэд ойр байгаа нь газрын үнэд эерэгээр нөлөөлөх боломжтойг харуулж байна.

Судалгаанд дүн шинжилгээ хийхэд:

1. Хот, суурины газрын сангийн удирдлагыг сайжруулахын тулд газрын удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлж, нийслэл, дүүргийн газрын албадын ажлын уялдаа холбоог сайжруулан Нийслэл, дүүрэг, аймаг, сумын Засаг даргын шийдвэрийн давхардлыг арилгах талаар хуулинд өөрчлөлт оруулах шаардлага гарч байна.

2. Газрын сангийн төлөвлөлт, удирдлагын гол механизм болсон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шаардлагын дагуу хийж, хот орчмын ХАА-н болон хотын барилгажсан хэсэгт хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу ойрын үед барилгажих газрын байршил, техникийн нөхцлийг мэргэжлийн байгууллагууд урьдчилан тогтоож, жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган олгох, газрын мэдээллийн санг нийтэд нээлттэй ил тод ажиллуулах, газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, төрийн ажилтны хариуцлагыг өндөржүүлэх. Ингэснээр барилгын байршил хэн нэг иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтээр биш хот байгуулалтын төлөвлөгөөний дагуу тогтоогдож газрын далд эдийн засгийг хязгаарлах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

3. Гэр бүлийн хэрэгцээнийхээс бусад газруудыг тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дуудлага худалдаагаар олгож байх, төсөл шалгаруулалтыг зөвхөн онцгой объектуудын хүрээнд зохион байгуулах, газар олголттой холбоотой бусад хууль эрхийн актуудад тодотгол, нэмэлт өөрчлөлт хийх нь зүйтэй юм.

4. Эрэлт хэрэгцээ өндөртэй, ачаалал ихтэй хот, суурины газрын асуудлыг тодорхой төлөвлөгөөгүй, удаан шийдэж байгаа нь нэг талаас газрын маргаан ихээр гарах нөхцлийг бүрдүүлэх, нөгөө талаас тухайн иргэн асуудлаа түргэн шийдүүлэх гэж танил тал, хээл хахууль өгөх зэрэг өөр далд аргаар хөөцөлдөх хууль бус үйл ажиллагааг хөгжүүлэхэд хүргэж байна.

5. Газрын харилцаанд баг, хорооны засаг дарга нар ямар нэг хэмжээгээр оролцож, заримдаа албан бус ам шийдвэр өгдөгөөс дураараа газар ашиглах нөхцлийг бүрдүүлж газрын маргааныг нэмэгдүүлж байна.

6. Алслагдсан дүүргүүд, тосгодод хийсэн судалгаагаар газрын харилцааг харьцангуй хурдан шийдэж байгаа нь тухайн хотын хүн ам, хот байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой бөгөөд Гачууртын хувьд газрын харилцааг

нийслэл дүүргийн Газрын албанаас зохицуулдаг нь асуудлыг шийдүүлэхэд хүндрэлтэй, төрийн үйлчилгээ иргэдээс холдсоныг харуулж байна.

7. Хот орчмын газруудад уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэхэд зохимжгүй бөгөөд Улаанбаатар хотын Гачуурт тосгон нь хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимжсэн ХАА-н бүс юм. Гэтэл Улаанбаатар хотод малтай айл өрхүүд уламжлалт мал аж ахуй эрхлэж байгаа нь бэлчээрийн доройтолд нөлөөлж, ойрын жилүүдэд бэлчээр сэргэхээргүй доройтож байгаад нийслэл, дүүргийн удирдлагууд анхаарч, ХАА-н үйлдвэрлэлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

/ “Case study”-г хуудас 45-49-аас үзнэ үү/

1.2.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн газар ашиглалт

ТХГН-ийн тухай хуулийн 7 дугаар бүлгийн 33. 1-д “Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно” гэж заасан байдаг.

Харин улсын тусгай хамгаалалтад авсан газар нутагт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, өмчлөх эрх хязгаарлагдмал байдгаас ТХГН-т зөвхөн тодорхой хугацаагаар газар ашиглах тухай асуудал яригддаг.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт амьдардаг иргэдийн 46. 4 хувь энэ нутгийн унаган иргэн, 4 ба түүнээс дээш жил амьдарч байна иргэд 40.6 хувийг эзэлдэг байна.

“ТХГН-т газар ашиглах зөвшөөрлийг орон нутгийн засаг захиргаанаас 17, ТХГН-ийн хамгаалалтын захиргаанаас 18, БОЯ-наас 5 иргэн авсан байгаагаас үзэхэд ТХГН-ийн тухай хуулийн 36.1-д заасан төрийн захиргааны төв байгууллага газар ашиглуулах тухай шийдвэр гаргана гэсэн заалт зөрчигдөж, ТХГН-ийн тухай хуулийг сахиулах үүрэгтэй хамгаалалтын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга нар хууль зөрчиж, зөвшөөрөл олгож байна.

Судалгаанаас харахад иргэдийн 12 хувь нь 5 жилээр газар ашиглах гэрчилгээ авсан, үлдсэн хувь нь хугацаа заагаагүй буюу зохих зөвшөөрөлгүй газар ашиглаж байна.

Газрын шинэтгэлийн бодлого, мэдээллийг 31 хувь нь телевизээс, 17 хувь нь сонин хэвлэлээс, 8 хувь нь радиогаас, 1.4 хувь нь төр захиргааны байгууллагын мэдээлэл сурталчилгаанаас авч байна гэснээс үзэхэд сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан явуулах нь илүү үр дүнтэй байгаа нь харагдаж байна.

ТХГН-т амьдарч буй хүмүүсийн дунд судалгаа явуулахад оролцогсодын 53 хувь нь өндөр албан тушаалтан, түүний хамаатан садан газрыг энд тэндгүй авч байна, 17 хувь нь хамгаалалтын захиргаа хууль зөрчсөн үйлдэл олныг явуулж байна, 11 хувь нь даац нь хэтэрчихээд байхад нэмж газар олгоод байна гэсэн хариулт өгчээ.

ТХГН дахь газар ашиглалтыг иргэдийн 45 хувь нь Газрын тухай хуулиар, 27 хувь нь ТХГН-ийн тухай хуулиар зохицуулах нь дээр гэж үзсэн нь ТХГН-ийн хуульд өрчлөлт оруулах шаардлагатайг харуулж байна.

Айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллага шигүү байрласан газар болох Зайсангийн ам нь дотоод бүсчлэлийн хувьд Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд ордог.

ТХГН-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5. 9-д зааснаар дархан цаазат газарт байнга ашиглах зориулалтаар аливаа барилга байгууламж барихыг хориглосон байдаг. Энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 1999 онд гарсан Байгаль орчны сайдын 136 дугаар тушаалаар Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт цаашид газар ашиглуулах чиглэлийг тогтоож, зориулалтыг баталгаажуулж, дээрх газруудад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор цаашид газар олгохыг зогсоосон шийдвэр гаргасан байна. Үүнд: Зайсангийн аманд Мэдээлэл сурталчилгааны төв, Хяналт шинжилгээний цэг, Экологийн боловсрол, сургалтын төв, Нийтийн амралтын үйлчилгээний түр цэгийн зориулалтаар газрыг зөвхөн ашиглаж болох бөгөөд өөр зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглосон юм.

Гэвч уг тушаалыг Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар хүчингүй болгосон нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар болон Богдхан уулын дархан цаазат газар тэр дундаа Зайсангийн аманд газар ашиглалтыг чөлөөтэй болгож, айл өрх, аж ахуйн нэгжүүдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, томоохон барилга байгууламжууд сүндэрлэн босох эх суурийг тавьсан буруу үйл ажиллагаа болсон байна гэж үзлээ. Тухайлбал: ХААИС-ийн биеийн тамирын талбайд томоохон барилга байгууламжууд баригдсан, Зайсан

толгойн зүүн урд талын энгэр дээр шинээр том хашаа барьсан /Солонгосын хөрөнгө оруулалттай компани томоохон цогцолбор барих/, Зайсан толгойн зүүн хойд талд байрладаг хуучин хүүхдийн халдвартын эмнэлгийн байранд солонгос айлууд 3-4 жил амьдарч байгаа, Зайсангийн амны уулын хормойд булгийн нүдэн дээр аялал жуулчлалын бааз байгуулж байгаль орчныг бохирдуулж байгаа, Зайсан толгойн зүүн талд 6-7 мал бүхий айл өрх 10-аад жил амьдарч байгаа зөрчил илэрсэн байна. Энэ нь ТХГН-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 9 дэх заалтыг зөрчиж байгаа болно.

Түүнчлэн Өмнөговь аймагт хийсэн мониторингоос үзэхэд Сэврэй сумыг ТХГН-т хамруулснаар байгалийн дагалт баялгийн ашиглалт хязгаарлагдмал болж, ард иргэдийн амьдрал хүндэрч, ТХГН-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд зөрчил үүсч байгаа нь харагдаж байна. Байгалийн цогцолбор газар нутагт Сэврэй сумын 394 иргэн бэлчээрийн зориулалтаар 43.25 га, 3 аж ахуйн нэгж аялал жуулчлалын зориулалтаар 7.2 га газрыг ашиглаж байна. Сэврэй сумын нутгийг ТХГН-т оруулахдаа малын өтөг бууц ашигладаг хорголон зуух, нарны цахилгаан үүсгүүрээр айл бүрийг хангана гэсэн нь хэрэгжээгүйгээс заг модыг түлшинд их хэмжээгээр хэрэглэж хуулийг зөрчихөөс өөр аргагүйд хүрч байна. Хонгорын голд ирэх жуулчдын тоо олширч үүнтэй холбоотойгоор малын бэлчээрт машин тэрэгний олон салаа зам гарч, гадаадын жуулчид дуртай газраараа явж бэлчээр талхлагдаж байгаа зөрчлүүд даамжирсан байна.

Ховд аймгийн Хар ус нуурын байгалийн цогцолборт газарт байдаг Чоно харайхын гол дээр баригдахаар зэхэгдэж байгаа усан цахилгаан станц нь байгаль орчинд зохих хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлнэ гэдгийг шинжлэх ухааны байгууллага судалгаагаар тогтоосон байна. Уг станцыг барьснаар нуурын усны түвшин ихсэж Далай нуур болон далангаас доошхи усны түвшинд өөрчлөлт гарч, цэнгэг усны экологи хийгээд орон нутгийн иргэд, мал сүргийн өвөлжилтийн байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна байнгын урсгалтай байдаг Чоно харайхын гол өвөл хөлдөж, нуурын зэгс усанд автаж, бэлчээргүй болох магадлал ажиглагдаж байна.

Улсын тусгай хамгаалалттай дээрхи газар нутгийн газар ашиглалтын байдалд хийсэн мониторингоос дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт, газар ашиглаж буй айл өрхийн тоо, малын тоо толгой, аж ахуйн нэгжүүдийн тоо жилээс жил ирэх

тусам нэмэгдэж, газрын даац хэтрэн, тусгай хамгаалалттай газар нутгийн мөн чанар нь алдагдаж, замбараагүй аялал жуулчлал, амралт зугаалгын бүс нутаг болон хувирсан байна. Үүний жишээ нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт газар ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2001 оныхоос 30 орчмоор нэмэгдсэн байна. Мөн нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлж гольфийн талбай байгуулах зориулалтаар их хэмжээний газрыг /350 га/ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид олгосон нь ТХГН-ийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

2. Богдхан уулын дархан цаазат газар Зайсангийн аманд аж ахуйн нэгж, байгууллагуудад газар ашиглах зөвшөөрөл олгож, олон тооны томоохон барилга байгууламжуудыг барьсан нь дархан цаазат газрын хамгаалалтын дэглэмийг ноцтой зөрчсөн хууль бус үйлдэл бөгөөд үүнд Байгаль орчны яам өөрөө оролцож, ТХГН-ийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүргээ хөсөрдүүлэн, ТХГН-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5, 33 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус зөрчиж байна.

3. Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт газар ашиглуулах чиглэл болон газар ашиглаж буй одоогийн зориулалтыг баталсан Байгаль орчны сайдын 1999 оны 136 дугаар тушаалыг хүчингүй болгосон нь дээрх газруудад эмх замбаараагүй газар ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байна.

4. ТХГН-ийн хилийн цэсэд газар нутаг нь ордог сум, дүүргийн засаг дарга нар ТХГН-ийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 9, 36 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус зөрчин газар ашиглуулах тухай захирамж гаргаж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар олгож байгаа нь аж ахуйн нэгж байгууллага болон хамгаалалтын захиргааны хооронд хэрүүл маргаан үүсгэж, хамгаалалтын горим, дэглэмийг сахиулах ажлыг улам хүндрүүлж байна.

5. Сэврэй сумын нутгаас ТХГН-т ордог Харын боомны Алаг-Өндөр гэдэг алтны илэрцтэй газраас нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд алт олборлож байгаа нь ТХГН-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1, 18 дугаар зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна. Сэврэй сумын удирдлагууд, ард иргэд газар нутгийнхаа зарим хэсгийг ТХГН-с гаргах асуудлыг тавьж байгаа нь тэндхийн айл өрхийн амьжиргааны төвшин доогуур байгаа, байгалийн нөөцийг ашигладаг хэрэгцээ нь ТХГН-ийн тухай хуультай зөрчилдөж байгаатай холбоотой гэж үзэж байна.

6. Мониторингийн судалгаанд хамрагдсан дээрхи ТХГН-уудад гарсан зөрчил нь тэдгээрийн хамгаалалтын асуудлыг хариуцсан хамгаалалтын захиргаад хуулиар хариуцсан үүргээ хангалтгүй биелүүлдэг, тэдний үүрэг хариуцлагыг орон нутагт төдийлөн анхаарч үнэлдэггүйтэй холбоотой гэж үзэж болох юм.

Цаашид дараахи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. ТХГН-ийн тухай хуулийн “ТХГН-т газар ашиглах, судалгаа шинжилгээний ажил явуулах” гэсэн 7 дугаар бүлгийг шинэчлэн ТХГН-т газар ашиглах, эзэмших, өмчлөх харилцааг тодорхой тусгаж өгөх, ялангуяа олон жил суурьшсан нутгийн унаган иргэдийн газар эзэмших, өмчлөх эрхийг баталгаажуулах

2. Газрын тухай хуульд “ТХГН-т газар ашиглуулах, эзэмших, өмчлөх асуудлыг ТХГН-ийн тухай хуулиар зохицуулна” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулах замаар ТХГН-т газар ашиглуулах асуудлыг нэг мөр болгож шийдвэрлэх

3. ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын зүгээс хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг хүчтэй болгож, зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу шийтгэл ногдуулж, хариуцлага тооцдог болгох, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг шинэ шатанд гаргах

4. Байгаль орчны яам болон эрх бүхий байгууллага ТХГН-ийн тухай хуулиар хориглосон ашигт малтмалын хайгуул хийх, ан амьтан барих, аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар барилга байгууламж барих зөвшөөрлийг олгодог зохисгүй явдлаа зогсоох

5. ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажилтнууд, сум, дүүргийн Засаг дарга нар ТХГН-т хууль зөрчин газар ашиглуулах зөвшөөрөл олгодгийг цаашид бүрмөсөн зогсоож, хуулиа дээдлэн хүлээсэн үүргээ чанд биелүүлэх

6. Дархан цаазат Богдхан уул, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт хууль зөрчин төрөл бүрийн зориулалтаар баригдсан барилга байгууламжуудыг нүүлгэн шилжүүлэх, татан буулгах замаар газраа чөлөөлж авах ажлыг Байгаль орчны яам, хамгаалалтын захиргаад ойрын үед зохион байгуулах арга хэмжээг авах

7. ТХГН-т амьдарч байгаа албан тушаалтан, иргэдээс тавьж байгаа саналыг үндэслэн ТХГН-т нөөц нь хүрэлцээтэй байгаа байгалийн баялгийг

тусгай зөвшөөрлийн үндсэн дээр иргэд, аж ахуйн нэгжүүд ашиглах нөхцлийг бүрдүүлж өгөх

8. Дөргөний усан цахилгаан станцын төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг яаралтай хийлгэж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг тогтоож, түүнийг багасгах талаар авах арга хэмжээг нарийн төлөвлөсний үндсэн дээр барилга байгууламжийн ажлыг хийлгэх, энэ ажилд байнгын хяналт тавьж ажиллахыг Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хар ус нуурын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд үүрэг болгох

9. ТХГН-т явуулах аялал жуулчлалын талаар ТХГН-ийн тухай хуульд “ТХГН-т явагдах аялал жуулчлал” гэсэн бүлэг нэмж оруулах

10. Нутгийн иргэдээр нь байгалийн баялгийг хамгаалуулах, ашиг шимийг нь хүртэж амьжиргаагаа дээшлүүлэх боломжийг хангаж өгөх

/ “Case study”-г хуудас 49-54-аас үзнэ үү/

1.2.3. Бэлчээрийн газар ашиглалт

Төрөөс бэлчээрийн менежментийн талаар баримтлах бодлого чиглэлийн гол агуулга нь бэлчээрийн газрын харилцааг эрх зүйн баталгаатай болгох, бэлчээрийг зохистой ашиглах, бэлчээрийг талхагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, бэлчээрийн төлөв байдлын хянан баталгааг хийх, бэлчээр ашиглалтын төлөвлөлт зохион байгуугуулалтыг боловсронгуй болгох, бэлчээрийн менежментийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Энэ зорилгоор бэлчээр ашиглалт, газрын шинэтгэлийн мониторингийн судалгааг Өмнөговь аймгийн Сэврэй сум, Ховд аймгийн Дөргөн сумуудад явуулсан болно.

Өмнөговь аймгийн Сэврэй суманд бэлчээрийн төрх, төлөв байдлын талаарх санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн 45% нь алаг цоогтой, 30% нь унаган төрхөө алдаагүй, 12% нь бэлчээр нэлэнхүйдээ талхлагдсан гэж хариулсанаас үзэхэд сүүлийн жилүүдэд ган зуд болж малын тоо толгой хорогдсон тул тухайн орон нутгийн хувьд одоогийн байдлаар бэлчээрийн талхагдал тийм их тулгамдсан асуудал биш боловч цаашид бэлчээрийн менежмент, зохицуулалтыг зөв хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Бэлчээрийг алаг цоогтой ашиглаж байгаа нь зах зээлд ойрхон төв суурин газруудын ойролцоох бэлчээр нутагт малтай иргэд ихээр төвлөрсөнөөс бэлчээрийг талхагдалд оруулж алслагдсан болон усан хангамж муутай бэлчээр нутгийг ашиглахгүй байгаатай холбоотой юм.

Бэлчээрийн доройтлын гол шалтгааныг ган, зуд олон тохиолдсоноос болон бэлчээрийг хуваарьтай ашиглаагүйгээс гэж хариулсан ч байгалын гамшгаас гадна сумын газар зохион байгуулалтын болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөө байхгүй, газрын асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтнууд өөрсдийн хүлээсэн эрх, үүргээ хангалтгүй биелүүлж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Мониторингоос дүгнэлт хийхэд: хөдөөгийн малчин иргэд бэлчээрийг ашиглахдаа ганц нэгээрээ бус хэсэг бүлгээрээ, удаан жилийн газар ашиглах гэрээний үндсэн дээр хуваарь сэлгээтэй ашиглах нь бэлчээрийн талхлагдлаас сэргийлэх гол арга хэмжээ бөгөөд бэлчээр нутгийг элдэв зөрчил маргаангүй ашиглах эрх зүйн чухал баримт бичиг нь гэрээ гэж ойлгодог болсон нь харагдаж байна. Ер нь манай малчин иргэдийн дунд чадалтай нь чадалгүйгээ, олон малтай чинээлэг малчид нь цөөн малтай ядуу ганц нэгнийхээ бэлчээр нутагт хүчээр түрэн орж, бэлчээрийг нь талхалдаг үзэгдэл түгээмэл байдаг бөгөөд үүнийг таслан зогсоох гол арга хэмжээ нь хэсэг бүлгээрээ нэгдэж бэлчээр ашиглах, бэлчээр дэх худгуудийг засварлах, шинээр худаг гаргах ажлыг эрчимжүүлэх явдал юм.

Бэлчээр ашиглалтын ерөнхий төлөв байдал, доройтлын шалтгаан, бэлчээрийг гэрээгээр ашиглах талаар иргэд, малчдын хариулсан байдлаас дүгнэлт хийхэд Газрын тухай хуулийн 52. 2-т заасны дагуу малчид тодорхой нөхцөл болзлын дагуу бэлчээрийг зөвхөн өвөл, хаврын улиралд гэрээгээр ашиглана гэсэн заалт нь хэрэгжих нөхцөл боломжтой гэдгийг харуулж байгаа боловч малчдын зүгээс жилийн 4 улиралд, бэлчээрийг удаан хугацаагаар, доод тал нь 15-20 жил гэрээгээр ашиглах сонирхолтой байгаа нь илт байна. Зарим асуулгад мэдэхгүй гэж зонхилох хэсэг хариулснаас харахад малчдын дунд Газрын тухай хуулийн талаарх мэдлэг хомс байгаа нь газрын асуудлыг хариуцдаг мэргэжилтэн, бүх шатны засаг дарга нь малчдын дунд сурталчилгаа бага хийдэгтэй холбоотой гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Бэлчээр ашиглалтын талаар гардаг гол маргаан зөрчлүүд нь уст цэгийн хангамж муу, хөрш зэргэлдээх сумдын нутагт орж гарахдаа бусдын бэлчээрийг талхладаг, ТХГН-т мал бэлчээрлүүлснээс, ашигт малтмал олзворлосноос гэж

хариулснаас дүгнэлт хийхэд говийн бүсэд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, эвдэрсэн худгуудыг сэргээн засварлах, хамтын гэрээгээр ашиглуулах, отор нүүдлийн бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах явцдаа мөрдөх тусгай заавар, журмыг боловсруулах, энэ талаар хуулинд шинээр заалт оруулж, хууль эрх зүйн хувьд шинэчлэлт хийх нь зүйтэй байна.

Бэлчээрийн маргааныг нийт иргэдийн 50 гаруй хувь нь урсгалаараа зохицуулдаг, 40-өөд хувь нь малчид хоорондоо зохицдог гэж хариулсанаас харахад бэлчээрийг ашиглах явцад гарсан аливаа маргааны зохицуулах эрх зүйн ямар нэгэн үндэслэл, журам зааваргүй урсгал байдлаар зохицуулж байгаа бөгөөд үүнийг хуульчилж өгөх нь зүйтэй юм.

Иймд төр захиргаанаас явуулж буй бодлогын чанартай асуудлууд малчид, иргэддээ хүрч чадахгүй, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөгүй учраас эмх замбараагүй урсгалаараа явагдаж байна гэж ойлгогдож байна. Иймээс газрын тухай хуулийн 52-р зүйлийн 8-д заасны дагуу бүх шатны засаг дарга нар, малчдын хооронд албан ёсны гэрээ хийлгэх, жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө бэлчээрийг зохистой ашиглах талаар тодорхой асуудлуудыг тусгасан заалт оруулах, малчид, иргэдэд газрын тухай хуулийг сурталчлах ажлыг эрчимтэй зохион байгуулах шаардлагатай байна.

Дээрхи байдлаас дүгнэлт хийхэд малчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь бэлчээрийн менежменттэй холбоотой асуудлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд маш чухал нөлөөтэй гэдэг нь харагдаж байна.

Сумын нутаг дэвсгэрт давс, нүүрс болон алт, шохойн ордтой боловч ТХГН-н хуулиар хориглодог ч иргэд зарим тохиолдолд алтны илэрцийг хууль бусаар ашиглаж алт угааж, орлого олдог байна. Мөн ТХГН-аас заг, гоёо түүх хориотой боловч 1 айл жилд дунджаар хоёр пургон машинаар загийг авч түлдэг, үүнийхээ төлөө 3000-5000 төгрөгөөр торгуулдаг байна. ТХГН-н талаар эдгээр сөрөг нөлөөлөл байгаа боловч байгаль орчноо хамгаалах талаар хяналт шалгалт сайжирсанаас гадна аялал жуучлалыг тухайн орон нутагт хөгжүүлсний үр дүнд малчдын дунд дан ганц мал аж ахуйг эрхлэх замаар орлого олох бус, гар урлал хийх, мал аж ахуйгаас гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах, морь малаа жуулчдад унуулж орлого олох замаар амьжиргааныхаа түвшинг дээшлүүлэх зэрэг давуу талууд олон байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Иймд ТХГН-ийн хуулинд зарим нэг өөрчлөлт оруулж, орчны бүсийг нарийвчлан тогтоох, газар нутгийн ашиглалтын статусыг шинэчлэх шаардлагатай болжээ гэж үзэж байна.

Ховд аймгийн Дөргөн сумын хувьд мониторингид оролцогсодын 50% нь бэлчээрийн талхлагдал алаг цоогтой, 30% нь унаган төрхөө алдаагүй, 20% нь бэлчээр нэлэнхүйдээ талхлагдсан гэсэн хариултаас дүгнэлт хийхэд бэлчээрийн талхагдал алаг цоог байгаа нь төв суурин газар болон худаг усаа бараадаж бэлчээр ашиглах явдал газар авсантай холбоотой. Алсын бэлчээрийг ашиглахгүй байгаа нь отор нүүдэл хийхэд тээврийн зардал ихтэй, малчдын нийгмийн асуудал хүндрэлтэй, төрөл бүрийн үйлчилгээ холдож байгаагаас болдог байна.

Бэлчээрийн доройтлын шалтгааныг ган зуд олон тохиолдсон, бэлчээрийг хуваарь сэлгээгүй ашигладаг, ямаан сүргийн тоо ихэссэнээс болсон гэж хариулсан байна.

Ер нь Ховд аймгийн ихэнх сумын хувьд ган зуд болсноос бэлчээрийн ургац буурч, царцаа ихэссэнтэй холбоотойгоор бэлчээр ихээр талхлагдаж ургамлын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс гадна бэлчээрийн гарц гайгүй, усан хангамж сайтай нутагтаа олноороо нэг дор бөөгнөрснөөс бэлчээрийг талхлаж, хуваарь сэлгээгүй уралдан идэх явдал газар авсан байна.

Мөн малчдын амьжиргааны түвшин ч бэлчээр талхагдалтанд нөлөөлж байгаа ба зах зээлийн харилцаа бодитойгоор хэрэгжиж буй өнөө үед малчдын хэрэглээ ихээр нэмэгдэж, үүнийгээ дагаж малын тоогоо өсгөх үү, малын үүлдэр угсаа чанарыг сайжруулан цөөн тооны чанартай малтай байх уу гэдэг асуудал малчдын өмнө чухлаар тавигдаж байна.

Малын үржил селекцийн ажлыг сайжруулан шилмэл үүлдрийн малаар эрлийзжүүлэх, тухайн бүс нутагт зохицсон өндөр ашиг шимтэй цөөн тооны малтай байх хүсэлтэй малчид олон байгаа боловч эдийн засгийн чадавхийн хувьд ихэнх малчид боломжгүй байна.

Иймээс малынхаа тоог өсгөхөөс өөр замгүй болж чанар муутай олон тооны малтай болох гэсэн хандлага газар авч, энэ хэмжээгээр бэлчээр ихээр талхлагдаж байна. Энэ байдлаас гарах нэг гарц нь малчид хэсэг бүлгээрээ хамтран хөрөнгө, хөдөлмөрөөрөө хоршин ажиллах явдал болно.

Бэлчээрийг сэргээн сайжруулахын тулд хэсэг бүлгээр, хуваарьтай ашиглах, нөхөн сэргээлтийн арга хэмжээ авах, доройтсон бэлчээрийг өнжөөх нь зүйтэй гэж хариулсанаас дүгнэлт хийхэд бэлчээрийг удаан хугацаатайгаар

ашиглах нөхцөлтэйгээр жилийн 4 улирлын бэлчээрийг ашиглах гэрээг байгуулах, гэхдээ малчин өрх тус бүрээр нь гэрээтэй ашиглуулах нь зүйтэй гэсэн хариултыг дийлэнх олонх өгсөн нь Газрын тухай хуулийн 52.2-д дурьдсан бэлчээрийг зөвхөн өвөл, хаврын улиралд тодорхой болзол гэрээний үндсэн дээр ашиглана гэсэн заалтыг судлах шаардлагатайг харуулж байна. Энэ нь отрын болон зун-намрын бэлчээрийг зохицуулах эрх зүйн ямар нэгэн баримт, хууль эрхийн акт байхгүйгээс бэлчээрийг уралдаж идэх, бэлчээрийн маргааныг бий болгох, хэт олноороо нэг дор бөөгнөрөн бэлчээрийг талхлах нөхцлийг бүрдүүлж байгаатай холбоотой юм.

Иймээс сумын газар зохон байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын бүлгүүдийн хил зааг, отрын бүс нутаг ашиглах болон бэлчээр сэлгэх хугацаа, нүүдлийн чиглэл зэргийг нарийвчлан тогтоож, зохих шатны иргэдийн хурлаар хэлэлцэн батлаж, гэрээ байгуулан ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Бэлчээр ашиглах явцад ихэвчлэн уст цэгийн ашиглалтаас, бэлчээр сэлгэх явцад бусдын бэлчээрийг талхалснаас, хөрш зэргэлдээх сумын нутагт ороход, ТХГН-т зөвшөөрөлгүйгээр мал бэлчээснээс, бэлчээр сүйтгэж ашигт малтмал олзворлосноос, бэлчээр ашиглах гэрээтэй малчдын нутагт зөвшөөрөлгүйгээр орсноос бэлчээрийн гол маргаан гарч байна гэж хариулсан нь малчид бэлчээр сэлгэж бусдын бэлчээрийг дайран гарахдаа хэт удаан хугацаагаар малаа бэлчээх, өвөлжөө хаваржааг нь нурааж буулгах, худаг уст цэгүүдийг эвдэх явдал гардагтай холбоотой ажээ.

Энэ байдлаас дүгнэлт хийхэд бэлчээр дэх худгуудийг засварлах, бэлчээрийг улирлаар сэлгэж ашиглах, отор нүүдэл хийх явцдаа бэлчээрийг ашиглах заавар журам боловсруулах, ТХГНутгийн ашиглалтын горимыг шинэчлэх, ашигт малтмал олзворлох явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажилд хяналт тавих ажлыг сайжруулах шаардлагатай байна.

Бэлчээрийн маргааныг малчид хоорондоо зохицдог гэсэн нь сум орон нутгийн удирдлагууд бэлчээрийн маргааныг зохицуулахад тэр болгон оролцдоггүй, малчдын өөрсдийнх нь шийдвэрлэх асуудал болгон орхидог, маргааныг зохицуулах журам зааваргүй учир урсгалаараа явдагтай холбоотойн нотолгоо юм.

Ган зуд болсон үед бэлчээр ашиглалтыг мөн л урсгалаар зохицуулдаг, цөөнх нь аман хэлэлцээр хийж, хөрш зэргэлдээх сумдтайгаа гурвалсан гэрээ байгуулдаг нь Газрын тухай хуулийн 52. 8-д Байгалийн гамшиг, гэнэтийн бусад

аюулын улмаас өөр аймаг сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны засаг дарга нар уг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заалт байгаа болохоос биш гэрээг бичгээр байгуулах тухай заалт байхгүй, хүлээх хариуцлагын механизмгүй байгаатай холбоотой бөгөөд энэ заалтад зохих өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Дөргөн сумын бэлчээр ашиглалтын хувьд гэхэд л нутгийн ихэнх хэсэг нь говь учир ургамал нь тачир сийрэг, бэлчээр нутаг нь талхагдалд их хэмжээгээр орсон, бэлчээр нутгаа сэлгэж ашиглая гэхэд түлээ түлш, усны асуудал хүндрэлтэй байдгаас алсын нөөц бэлчээрээ ашиглаж чаддаггүй байна.

Дээр дурьдсан хүндрэлтэй байдлуудаас гарахын тулд тухайн орон нутгийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, алсын бэлчээрийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, орон нутгийн түүхий эд материалыг ашиглаж шахмал түлш хийх технологийг нэвтрүүлэх, хямд төсөр түлшээр малчдыг хангах, газрын тухай хуулийн 58-р зүйлд заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх шаардлагатай байна.

Судалгаа явуулсан дээрх хоёр сум нь байгаль газар зүйн байрлалаараа эрс өөр бүсэд байрладаг боловч бэлчээр ашиглалтын байдалд гарч буй тулгамдсан асуудлууд, газрын тухай багц хуулийг хэрэгжүүлэх явцад учирч буй бэрхшээлүүд түүнчлэн газрын тухай хуулийн зарим заалтуудад тодотгол нэмэлт хийх шаардлага гарч байгаа нөхцөл байдлууд зэрэг нь бараг адилхан байна.

Судалгааны дүнгээс харахад бэлчээр ашиглалтанд дараах үндсэн түгээмэл тулгамдсан асуудлууд байна.

1. Бэлчээрийн усан хангамж муу, бэлчээр дэхь худгууд эвдэрсэнээс алсын бэлчээрийн ашигладаггүй, отрын нөөц бэлчээр дутмаг байдаг.
2. ХАА-н бүтээгдэхүүн борлуулах зах зээл, дэд бүтцийн сүлжээ нь бэлчээр дэх уст цэгээ бараадаж, хүн, малын бөөгнөрөл ихэссэнээс төв, суурин газрын ойролцоох бэлчээр их талхлагдаж байна.
3. Бэлчээрийг улирлын хуваарь, сэлгээгүй ашигласнаас бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, ургацын чанар нь муудсан.
4. Малчдын амжиргааны түвшин ерөнхийдөө доогуур, бие биендээ итгэх итгэлцэл бага, хамтдаа ажиллах сонирхол муу учраас малын чанар, үүлдэр угсааг сайжруулах замаар цөөн тооны, өндөр ашиг шим бүхий

малтай байх сонирхол байсан ч хөрөнгө мөнгөний хомсдлоос болж амьдрал дээр хэрэгжихэд бэрхшээлтэй байдаг.

5. Малын тоо толгойг өсгөх замаар үйлдвэрлэлээ өргөтгөж, хэрэгцээгээ хангах сонирхол газар авснаас бэлчээр, малын хоорондын харьцаа алдагдаж байна.
6. Бэлчээр ашиглах явцад гарч буй маргааныг зохицуулах эрх зүйн баримт бичиг дутмаг, хариуцлага тооцох механизм байхгүй, гол төлөв урсгалаараа зохицуулагдаж байна.
7. Төр захиргааны дунд, доод шатны удирдах албан тушаалтнууд болон ард иргэдийн дунд газрын харилцааны эрх зүйн талаархи мэдлэг сул байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй явагдаж байна.
8. Газар ашиглалтын судалгаа, зураглал, төлөвлөлт болон менежментийн орчин сул дорой бүрдсэн, орчин үеийн багаж тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн сүлжээ дутагдаж байна.
9. Бэлчээрийн газрын төлөв байдлын хянан баталгаа хийгдээгүй, бэлчээрийн зураглал байхгүй байгаа нь газар эзэмшлийн гэрээ хийх болон бэлчээрийг талхагдалд оруулсан нөхцөлд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэлгүй болгож байна.
10. Тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээнд газар ашиглах, эзэмших эрх зүйн харилцаа нь ТХГН-ийн ашиглалтын горимын дагуу зохицуулагддаг учир ТХГН-т нутаг дэвсгэр нь хамаарагддаг сумдын төр, захиргааны эрх бүхий албан тушаалтнууд, иргэдийн эрх хязгаарлагдмал байна.
11. Бэлчээрийг төлбөргүй ашиглаж байгаа нь бэлчээрийг талхлах, доройтолд оруулах нэг үндсэн нөхцөл болж байна.

Сэврэй, Дөргөн сумдад газрын шинэтгэлийн мониторингийн чиглэлээр явуулсан судалгаанд үндэслэж дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Газрын тухай хуулийн 52-р зүйл буюу бэлчээр түүнийг зохистой ашиглах хамгаалах гэсэн хэсэгт зун-намрын бэлчээрийг нийтээр, дундаа ашиглана гэсэн заалтыг гэрээний үндсэн дээр, тусгай болзолтойгоор ашиглуулахаар тусгах. Мөн бэлчээр дэхь уст цэгүүдийг малчдад гэрээгээр ашиглуулах асуудлыг тусгах.

2. Бэлчээрийг хуваарь сэлгээтэй ашиглах гол арга нь малчдыг хот айлаар, хэсэг бүлгээр зохион байгуулах явдал юм. Иймээс Газрын тухай хуулийн 21-р зүйлд Сум, багийн засаг дарга нарын эрх үүрэгт энэ асуудлыг хуульчлан оруулах
3. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний гол хэсэг нь бэлчээрийн судалгаа байдаг бөгөөд үүнийг орчин үеийн техник тоног төхөөрөмж, (GPS) багаж ашиглан тоон мэдээллээр судалгаа явуулж, тусгай программ хангамжийн дагуу боловсруулалт хийх хөрөнгийг жил бүр сумын төсөвт тусгуулах арга хэмжээг авах
4. Орон нутагт Газрын бүртгэл, кадастрын зураглалын мэдээллийн сүлжээг бий болгож, газрын мэдээллийн системийг сайжруулах
5. Бэлчээрийн маргааныг зохицуулах заавар, журмыг нарийвчлан гаргах, Газрын тухай хуулийн 48 –р зүйлд бэлчээрийн газрыг дайран өнгөрөх тухай заалт нэмж оруулах
6. Газрын хуулинд заасан сум, багийн засаг дарга нарын эрх, үүргийг тодорхой болгох, бэлчээрийн газрын гэрээг заавал хийсэн байх талаар хуульчилж өгөх
7. Газар өмчлөлийн хуулинд “Иргэнд газар өмчлүүлнэ” гэсэн үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж, иргэн бүрт газар өмчлүүлэх асуудлыг тусгах
8. Бүх шатанд Газрын хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх сургалт, суртачилгаа зохион байгуулах, гарын авлага, журам заавар бэлтгэж тараах, хөдөөгийн хүүхдүүдэд дунд сургуулийн сургалтын программд нь бэлчээрийн газрын менежментийн талаар тусган оруулах
9. Газрын менежментийн мэргэжилтэй боловсон хүчнээр сум орон нутгийг хангах
10. Бэлчээрийг төлбөртэй болгож, одоо малын хөлийн хөлийн татвар гэж нэрлээд байгаа хүн амын орлогын албан татварыг малчдаас авдагаа больж, борлуулсан бүтээгдэхүүнд нь ногдуулдаг эдийн засгийн механизмыг бий болгох.

1.2.4. Уул уурхайн газар ашиглалт

Энэ чиглэлээр Төв аймгийн Заамар суманд хийсэн мониторингоос үзэхэд Туул голын хөндийд 1990 оны эхнээс алт олборлох үйл ажиллагаа өрнөж, 1999 онд 28 аж ахуйн нэгж, байгууллага байсан бол одоогийн байдлаар

36 болж нэмэгдэн алт олборлох үйл ажиллагаа явуулж байгаа юм байна. Алт олборлох үйл ажиллагаа нь нэг талаараа Монгол орны эдийн засагт чухал хэрэгцээтэй хэдий ч нөгөө талаар байгаль орчинд сөрөг нөлөөллийг их хэмжээгээр үзүүлж байгаа нь сүүлийн 10 гаруй жилийн байдлаас харагдаж байгаа юм.

Заамар сумын нутаг дахь Туул голын хөндийд алтны олборлолт эрчимтэй явагдаж байгаа хэдий ч нөхөн сэргээлтийн ажлыг хангалтгүй хийдэг байна. 2004 оны байдлаар тус суманд ашигт малтмал ашиглах 44 лиценз эзэмшигч байгаагаас, 18 нь олборлолтын үйл ажиллагаа явуулсан байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд 216.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн нь нийт эвдэрсэн газар болох 5000 орчим га- тай харьцуулахад туйлын хангалтгүй байгаа нь харагдаж байна. 5090.6 кг алт олборлохын тулд 538.83 сая төгрөгийн зардал гаргаж ажилласан байна.

Дээрхи статистик мэдээллээс харахад олборлолтын хэмжээ ихсэж байгаа боловч нөхөн сэргээлтийн ажил хангалтгүй хийгдэж, түүнд зориулан гаргаж буй хөрөнгийн хэмжээ бага байгаа юм. Түүнчлэн нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу бус зөвхөн буцааж булах төдийхнөөр хийж, оромдож байгаа нь харагдлаа. Байгалийн биологийн нөхөн сэргээлтэд төдийлөн анхаарахгүй байгаа нь цаашид уг газрыг хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах боломжийг бууруулж байгаа муу талтай.

Мөн ашигт малтмал ашигласны дараа газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх, алт олборлолтын зүй зохистой технологийг нэвтрүүлэх тал дээр төр захиргаа, орон нутгийн байгууллагууд туйлын хангалтгүй ажиллаж байгаа нь илэрхий байна. Тухайлбал Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тухайн алтны ордыг ашиглахад орчиндоо ямар нөлөөлөл үзүүлэхийг хугацаагаар тооцож, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг цаг хугацаатай нь уяж үнэлбэл илүү үр дүнтэй байх болно гэж үзэж байна.

Одоо хийгдэж байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүд нь зөвхөн мөнгө олохын төлөө ор нэрийн төдий хийсэн ажил болж, нөхөн сэргээлтийн төсөл боловсруулсан ч үнэлгээний тайланд хавсрагдахгүй байгаа зэрэг зөрчлүүд гардаг байна.

Туул голын хөндийд нутаглаж буй Заамар сумын 50 орчим айл өрхөөс Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилт, түүний ололттой, дутагдалтай талууд болон алт олборлолтоос

иргэдэд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөнүүд, нөхөн сэргээлтийн ажлын явцын талаар тодруулах зорилгоор мониторинг хийхэд нийт оролцогсодын 27% нь газраа хэрхэн өмчилж авахаа мэдэхгүй байна, 29% нь нутгийн унаган иргэд учир газраа өмчилж авах шаардлагагүй, 18% нь өргөдлөө өгч амжаагүй байна гэсэн хариулт өгсөн нь тус сумын иргэд газар өмчилж авахад яарахгүй байгааг харуулж байна. Түүнчлэн тус суманд өөр аймаг, сумуудаас айл өрх олноор нүүн ирж сууршин, ажиллаж амьдарч байгаа, тэд л зөвшөөрөл авах хэрэгтэй болохоос нутгийн уугуул иргэд бид давуу эрхтэй оршин сууж, зөвшөөрөл авах шаардлагагүй гэж үзсэн нь шилжилт хөдөлгөөнийг зохицуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Мөн оролцогсодын 32% нь алт олборлох нь буруу гэж үзэж байхад, 11% нь зөв гэж хариулсан боловч нөхөн сэргээлт хийгдэхгүй байна, 11% нь зөв, гэхдээ ашигт малтмалыг хэт их ашиглаж нөөцгүй болгож байна, 9% нь зөв, гэвч ажилгүй иргэдийг ажилтай болгомоор байна, ашиглалтад зохицуулалт хэрэгтэй байна гэснээс дүгнэлт хийхэд Заамар сумын иргэдийн дийлэнх нь алт олборлолтыг буруу гэж үзээгүй бөгөөд зөвхөн уг ажлын зохицуулалтыг сайжруулж, нөхөн сэргээлтийг журмын дагуу бүрэн хийх шаардлагатай байгааг харуулж байна. Иймд төрийн зүгээс болон орон нутгийн зүгээс тавих хяналт шалгалт, шаардлагыг сайжруулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Нэгэнт ачаалал нь ихэдчихээд байгаа газарт дахин лиценз нэмж олгох, нөхөн сэргээлтийн ажлыг огт хийдэггүй аж ахуйн нэгжүүдийг дараа жил нь тухайн газарт дахин ажиллуулдаг зөрчлийг зогсоох шаардлагатай байна.

Иргэдийн 40% нь нөхөн сэргээлтийг зохих ёсоор хийдэггүй, ашигласан газраа хагас дутуу тэгшилсэн болоод орхидог, 53% нь ухсан нүхээ тэр чигт нь орхидог гэж хариулсанаас харахад алт олборлож буй компаниуд ашгийн төлөө хэт хөөцөлдөж, байгаль орчныг хамгаалах тал дээр огт анхаарал тавихгүй байгааг харуулж байна.

Алтны уурхайн нөхөн сэргээлтийн стандарт 2000 онд батлагдан мөрдөгдөж эхэлсэн боловч уг стандартыг мөрдөж ажилладаг аж ахуйн нэгж, байгууллага өнөөдөр алга байна. Ихэнх тохиолдолд ухсан газраа хагас дутуу булаад орхидог нь орон нутгийн зүгээс тавьж буй хяналт муу байгаатай ч шууд холбоотой юм.

1999 оноос эхлэн ард иргэд байгалийн баялаг руу улайран дайрч, хууль бусаар алт олборлогчид олширч, уурхайнуудын нөхөн сэргээсэн газрыг дахин сэндийлж алт олборлож эхэлсэн байна. Тухайлбал Заамар суманд 5000 орчим

иргэд хууль бусаар алт олборлож байгаа нь мөн л алтны уурхайнуудын одоо хэрэглэж буй техник технологитой шууд холбоотой юм. Алтны уурхайнууд анхнаасаа алт олборлох хаягдалгүй технологи ашиглаж, нөхөн сэргээлтийг журмын дагуу хийсэн бол хууль бусаар алт олборлогчид тэдний нөхөн сэргээлт хийсэн талбай руу орох боломжгүй бөгөөд эндээс алтны уурхайнууд хэрэглэж буй техник, технологио сайжруулах шаардлага зайлшгүй урган гарч байгаа юм.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн талаар мониторингид оролцогсдын 60% нь уг хууль 2002.6.28-наас өмнө гэр бүлээ бүртгүүлсэн тохиолдолд газар өмчилнө гэж хүний эрхийг зөрчсөн, 20% нь иргэнд газар өмчлүүлнэ гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн, 7% нь хууль хэрэгжих нөхцөл нь бүрдээгүй байсан, 22% нь цаг үеэ олсон сайн хууль болсон гэж хариулсан нь оролцогсодын 78% нь ямар нэг шалтгаанаар уг хуулийг буруутгасан байгаа ба үүнээс хууль хэрэгжих нөхцөл бүрэн бүрдээгүй байсан гэсэн дүгнэлт гарч байна.

МАА-н зориулалтаар ямар газрыг хувьчлах нь зохимжтой талаар оролцогсодын 40% нь өвөлжөө хаваржааны газрыг, 44% нь уулын бэл, гол горхины дэргэдэх газрыг, 11% нь бэлчээрийг хувьчилж болохгүй гэж хариулсан ба бэлчээрийн доройтлын шалтгааныг уул уурхайн буруу үйл ажиллагаа болон олон жил дараалан ган зуд давтагдаж байгаа зэргээс болсон гэж үзэж байгаа бөгөөд мониторингид оролцогсод нь алтны олборлолтоос үүссэн ихээхэн хэмжээний сөрөг нөлөөлөлд орсон иргэд байна.

Бэлчээр сайжруулах арга замын талаар 53% нь ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хязгаарлах, 27% нь биологийн аргаар нөхөн сэргээлт хийх, 9% нь бэлчээр ашиглах бүлэг байгуулах шаардлагатай гэж хариулснаас харахад ашигт малтмал олборлох ажиллагааг хязгаарлаж, биологийн аргаар нөхөн сэргээлт хийхээс өөрөөр бэлчээрийг сэргээнэ гэж ярих нь үр ашиггүй болно гэдгийг илэрхийлж байна.

Сөрөг нөлөөллийн талаар малчид хариулахдаа 91% нь бэлчээрийг их хэмжээгээр сүйтгэж байна гэсэн нь ойрын хугацаанд ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааг анхаарч зохицуулах шаардлагатайг харуулж байна.

1.2.5. Газар тариалангийн газар ашиглалт

...
...
166 ... /.../ 9960 ...
...
...
...жээ.

... 126 ...
...оос 9 ... 916 ...
... 37 ...
...сэн байна. ...
... газар өмчлөлийн а... яв...
...
...ын ...
...г ...
...уулж

- ... 3 ... 306 ... а ... 44 ... 19 ... 15 ... 5 ... хувьчилбал зүйтэй гэж, 17 ... дүн гарсан

- ... талаар 29,1 ... 26,1 ... 14,7 ... 10,2 ... 1,3 ... 18,6 ... талаар 58 ...

...
...ээр гэж
...
...цөөнх ...
...г
...уулж

...
...

Эрүүгийн шинж чанартай хэргийн талаар өргөдөл гомдол хүлээн авч, хэргийг бүртгэн мөрдөн байцаалт явуулах замаар шүүхэд шилжүүлдэг бөгөөд 2000-2004 онд 29 өргөдөл ирүүлсэн байна. 2001 онд 5 өргөдөл, 2002 онд 8 өргөдөл, 2003 онд 10 өргөдөл, 2004 онд 8 өргөдөл ирүүлсэн байна.

2000-2004 онд 29 өргөдөл ирүүлсэн байна. 2001 онд 5 өргөдөл, 2002 онд 8 өргөдөл, 2003 онд 10 өргөдөл, 2004 онд 8 өргөдөл ирүүлсэн байна.

2001 онд 5 өргөдөл ирүүлсэн байна. 2002 онд 8 өргөдөл ирүүлсэн байна. 2003 онд 10 өргөдөл ирүүлсэн байна. 2004 онд 8 өргөдөл ирүүлсэн байна.

2004 онд 8 өргөдөл ирүүлсэн байна. 2001 онд 5 өргөдөл, 2002 онд 8 өргөдөл, 2003 онд 10 өргөдөл, 2004 онд 8 өргөдөл ирүүлсэн байна.

Нийтдээ ирүүлсэн өргөдөл 29 байна. 2001 онд 5 өргөдөл, 2002 онд 8 өргөдөл, 2003 онд 10 өргөдөл, 2004 онд 8 өргөдөл ирүүлсэн байна.

Үүнийг үндэслэн: 2000-2004 онд 29 өргөдөл ирүүлсэн байна. 2001 онд 5 өргөдөл, 2002 онд 8 өргөдөл, 2003 онд 10 өргөдөл, 2004 онд 8 өргөдөл ирүүлсэн байна.

сурталчиллаа. Мөн төслийн хэрэгжилтийн явцын талаар “Монголын мэдээ” сонинд нүүр бэлтгэж гаргалаа.

Газрын шинэтгэлийн асуудлаар хэвлэл мэдээллээр нийтлэгдсэн материалуудыг цуглуулан дүн шинжилгээ хийж, мэдээллийн сангаа баяжууллаа.

Гурав. Төслийн хэрэгжилтийн явцад зохион байгуулсан семинарын талаар

2004 оны 11 сарын 19-ны Баасан гаригт судалгааны ажлын явц, үр дүнгийн талаар “Газрын шинэтгэлийн мониторинг” сэдэвт семинарыг мэдээлэл технологийн үндэсний парсад байгаль орчны төрийн бус байгууллагууд, олон нийтийн хүрээнд зохион байгууллаа.

Семинарт Нээлттэй Нийгэм Форумын ажилтан Н.Дорждарь, ГХГЗЗГ-ын хэтсийн дарга Ч. Гомбосүрэн, Монголын “Озоны нийгэмлэг”-ийн тэргүүн Ц.Адьяасүрэн, дүүргүүдийн газрын албадын дарга нар, Улсын Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтнүүд, Сэлэнгэ, Өмнөговь, Ховд аймгийн төлөөлөгчид, Их, дээд сургууль болон шинжлэх ухааны хүрээлэнгийн эрдэмтэд, БОЯ, байгаль хамгаалах нийгэмлэгийн ажилтнууд, байгаль хамгаалах чиглэлээр ажиллаж буй төслийн болон ТББ-ын ажилтнууд, УИХ-ын байнгын хорооны зөвлөх Д.Мягмарсүрэн, Гэр хороололд амьдрагсдын эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн Н. Нагаанбуу нар болон Гачуурт тосгон, нийслэлийн зарим хороодын засаг дарга нар, иргэдийн төлөөлөгчид мөн телевиз, радио, хэвлэл мэдээллийн сурвалжлагчид оролцлоо.

Семинарыг “Байгаль 21” ТББ-ын тэргүүн Ж. Осоржамаа нээж, Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн талаар танилцуулж, Монгол улсад газрын шинэтгэл хэрхэн явагдаж байгаа талаар болон холбогдох хуулиудын хэрэгжилт ямар байгааг сонгосон нэгжүүдэд судлах, газар өмчлүүлэх ажлын явцад гарч буй зөрчил маргаан, санал бодлыг нэгтгэн дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал зөвлөмж боловсруулах зэрэг чиглэлээр хэрэгжүүлж буй мониторингийн талаар ярилаа.

Судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, мониторингтой холбогдсон асуудлуудаар газрын харилцааны байгууллагын албан тушаалтан нар болон төслийн экспертүүдийн бэлтгэсэн илтгэлийг сонсож хэлэлцлээ. Үүнд:

1. Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц
2. Хот суурины газрын харилцаанд хийсэн мониторингийн үр дүн
3. УТХГН-т газар ашиглалтын байдалд хийсэн мониторингийн үр дүн
4. Тариалангийн талбайн хувьчлалын өнөөгийн байдал, боловсронгуй болгох боломж
5. Бэлчээрийн менежмент, газрын харилцааны асуудал
6. Газрын хууль тогтоомжийн хяналтын талаар
7. Баянгол дүүргийн шүүхээс газартай холбогдсон хэргийг шийдвэрлэсэн байдалд хийсэн мониторингийн үр дүн
8. Төв аймгийн Заамар сумын алтны уурхайнуудын газар ашиглалтын байдал, нөхөн сэргээлтийн явц
9. Хөдөө аж ахуйн газрын элэгдэл эвдрэл, экологийн доройтол
10. Зайсангийн амны газар ашиглалтын байдлын талаар
11. Газар өмчлөл - гэр хороололынхны амьдралд
12. Өмнөговь аймгийн Говь Гурвансайхны БЦГ-ын газар ашиглалтын байдал
15. Ховд аймгийн Хар ус нуурын БЦГ-ын газар ашиглалтын байдал
16. Судалгаа мониторингийн объектуудад хийгдсэн ажилд өгөх нэгдсэн үнэлгээ, дүгнэлт зэрэг болно.

Семинарын үеэр судалгааны ажлын явцыг харуулсан зурагт самбар гаргаж, ММ агентлаг, TV 25 телевиз, “Улаанбаатар таймс”, “Байгаль”, “Монголын мэдээ” сонин, Монцамэ агентлаг, Монголын радиогоор семинарын явц, үр дүнг мэдээлсэн болно.

3.1. Семинар дээр тавигдсан илтгэлүүдээр тайлан бичиж бэлтгэлээ.

Дөрөв. Экспертүүдийн дүн шинжилгээний ерөнхий дүгнэлт

4.1. Газар ашиглалтын гол чиглэлүүдээр гаргасан дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Семинарт оролцсон төслийн экспертүүд болон төлөөлөгчид 3 группээр ажиллаж, газар ашиглалтын гол чиглэлүүдээр гарсан асуулт, хариулт, саналыг нэгтгэн дүгнэлт гаргалаа. Тухайлбал: Газрын шинэтгэлийн хамрах хүрээг эрх зүй, удирдлага-зохион байгуулалт, газрын эрхийн харилцаа /Ашиглалт, эзэмшил, өмчлөл/ гэсэн 3 чиглэлд хувааж, чиглэл тус бүрээр хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан холбогдох байгууллагуудад өгөхөөр бэлтгэв.

4.1.1. Тусгай хамгаалалттай газар нутаг

4.1.2. ХАА-н газар

4.1.3. Хотын газар

4.1.1. Тусгай хамгаалалттай газар нутаг

а. Эрх зүйн хүрээнд:

1. ТХГН-ийн тухай асуудлыг Засгийн газрын мэдлээс гаргаж, ҮАБЗ-ийн мэдэлд шилжүүлэх
2. ТХГН-ийн хуульд өөрчлөлт оруулж, газрын харилцааны асуудлыг зохицуулах
3. ТХГН-ийн тухай хуульд аялал жуулчлал эрхлэх талаар нэмэлт зүйл, заалт оруулах
4. ТХГН-ийн арга хэмжээний торгууль, төлбөрийг нэмэгдүүлэх
5. Орчны бүсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
6. Олон жил тухайн нутагт амьдарч байгаа иргэдийн эрхийг хангах
7. Уугуул иргэдэд тухайн нутгийн байгалийн баялгийн ашиг шимийг хүртэж, амьжиргаагаа дээшлүүлэх эрх олгох

б. Удирдлага, З/б-ын хүрээнд:

1. Сум, дүүргийн засаг дарга нар /ТХГН-ийн хамгаалалтын захиргааны дарга нар/ ТХГН-т газар ашиглах зөвшөөрөл олгодгийг зогсоох
2. Эрх бүхий байгууллагууд /БОЯ, ГУУГ гм/ ТХГН-т хориглосон үйл ажиллагааны чиглэлээр зөвшөөрөл олгодгийг зогсоох
3. Даац нь хэтэрсэн зарим газарт Байгаль орчны даацын үнэлгээг хийж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах
4. ТХГН-ийн талаар удирдах байгууллагаас гарч буй шийдвэрийг олон нийтэд ил тод болгох

в. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар

1. Орон нутгийн ард иргэдэд тулгуурласан Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежментийг хөгжүүлэх /малчид, иргэдийн нөхөрлөлийг дэмжих/

4.1.2. ХАА-н газар

1. Газрын тухай хуулийн 52.2-д ... сумын засаг дарга бэлчээрийн газрыг малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно ... гэсэн заалтыг “сумын засаг дарга бэлчээрийн газрыг малчдын бүлэгт, хамтлагт сум, багийн өөрөө удирдах ёсны байгууллагын албан ёсны санал шийдвэрийг үндэслэн болзол гэрээний дагуу эзэмшүүлэх шийдвэр гаргаж, тодорхой хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна” гэж өөрчлөх.

Учир нь одоогийн нөхцөл байдлаас дүгнэлт хийхэд хэсэг бүлэг малчид нь гэрээгээр бэлчээр нутгаа эзэмшиж өөрийн эзэмшлийн бэлчээр нутгаа сэлгээтэй ашиглах, сайжруулалт хийж хөрөнгө оруулах гэтэл газрын тухай хуулийн 3.1.3-д заасан ... өөрийн мэдэлд байлгах “ гэсэн заалт хэрэгжихгүй болж байгаа юм.

Мөн газрын тухай хуулийн 52.2-д заасны дагуу ... “ашиглуулж болно” гэж хуулчилсан учраас тухайн сумын засаг дарга бэлчээр ашиглах гэрээг хийж болно, хийхгүй байж ч болно гэсэн утга санааг агуулж буй учир зарим сумдад гэрээг хийхгүй байгаагаас бэлчээр нутаг булаацалдах маргаан гарах, хэн дуртай нь бусдын нутагт дураараа орох зөрчлийг бий болгож байгаа юм.

2. Газрын тухай хуулийн 48-р зүйлд нэмэлт болгож “ бэлчээрийн газрыг дайран өнгөрөхдөө тухайн сумын ИТХ-аар баталсан бэлчээрийн газрыг дайран өнгөрөх журмыг баримтална” гэж оруулах.

Учир нь улирлын сэлгээтэйгээр отор нүүдэл хийж, бэлчээр ашигладаг сумдад нэг багийн малчид нь нөгөө багийнхаа нутаг дээгүүр зайлшгүй дайран өнгөрөх шаардлага гардаг бөгөөд бусдын бэлчээрт хэт удаан байж малаа бэлчээх, өвөлжөө хаваржааг нь эвдэж сүйтгэх, газар нутгийн аль сортой бэлчээрийг нь ашиглаж талхлах зэрэг зөрчил гардаг юм. Иймээс тухайн сумын ИТХ нь отор нүүдэл хийж буй малчид хаагуур явж өнгөрөх, ямар хугацаагаар нэг суурин дээр байх зэргийг нарийвчлан тогтоосон журам боловсруулсан байх шаардлагатай байгаа юм.

3. Газрын хуулийн 52.5-д ... “тодорхой болзол гэрээний дагуу ашиглаж болно” гэдгийг “тодорхой болзол гэрээний дагуу эзэмшүүлнэ” гэж өөрчлөх.

Учир нь өөрийн эзэмшилд байгаа нөхцөлд хөрөнгө оруулалтыг газартаа оруулах сонирхол төрнө. Эзэмших эрхийн гэрчилгээгээ банкны барьцаанд тавих нөхцөл бүрдэнэ.

4. Газарын тухай хуулийн 52.8-д ... Байгалын гамшиг гэнэтийн аюулын улмаас өөр аймаг сумдын нутагт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны засаг дарга нар гурвалсан гэрээ хийнэ гэсэн заалт оруулах.

Учир нь гэрээ хийж, тусгай болзол нөхцлийг нь заахгүй бол, нөгөө талаас газрын төлбөр /бэлчээр ашигласан/ нэхэх, гэрээнд заагаагүй бусад нөхцлийг шаардах зэргээр маргаан гарч болзошгүй юм.

5. Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйл: “газар ашиглах” гэсэн бүлэгт дан ганц гадаадын иргэдийн эрх зүйн зохицуулалтын талаар орсон болохоос биш бэлчээр, хадлан, тариалангийн болон бусад газрын ашиглалтын талаар /27-43 дугаар зүйл/ тодорхой заалт байхгүй байна.

6. Ашигт малтмалын тухай хууль /лицензийн асуудал/, ТХГН-ийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль, Үндсэн хууль зэрэг олон хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөөнтэй байгаа учраас газар нутгийн маргаан их гардаг байна.

7. Бэлчээрийн тухай тусгай хууль боловсруулж бэлчээрийн газрыг төлбөртэй болгох , бэлчээрийг нөхөн сэргээхэд зориулсан тусгай сан байгуулах.

Учир нь одоогийн байдлаар бэлчээрийг орон нутгийн хэмжээнд сайжруулах хөрөнгө байхгүй байна. Одоогийн байдлаар улсын төсвөөс бэлчээрийн нөхөн сэргээлт явуулдаг гэх боловч энэ нь гол байршлаа олохгүй, ашиг багатай газруудад хөрөнгө зарцуулж байна. Иймд бэлчээрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын статусыг тодорхой болгох шаардлагатай юм.

8. Хөдөө орон нутгаас малтай иргэд хотод орж ирэх нь ихсэж байгаа учир үүнийг төрийн зүгээс зохицуулах бодлого боловсруулах. Газар тариалан МАА-г хослуулан, эрчимжсэн МАА-г хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл, тариалангийн газрыг иргэдэд үнэгүй өмчлүүлж орчных нь бэлчээрийг удаан хугацаагаар эзэмшүүлэх хэрэгтэй байна.

9. Бэлчээрийн менежментийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төслүүдийн уялдаа холбоог сайжруулах.

10. Хуулинд хадлангийн талбайг гэрээгээр эзэмшүүлэх, ашиглуулах гэсэн заалт оруулах.

Одоогийн хуулийн 53.2-д “Сум дүүргийн засаг дарга, хадлан авах бололцоотой талбайг жил бүр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулахаар баг хорооны ИТХ-ын саналыг хуваарилж, түүний хэрэгжилтийг зохион байгуулна” гэсэн нь жил бүр ашиглагч нар нь солигдоно гэсэн санааг агуулж байна. Энэ нь хадлангийн талбайг хашиж хамгаалах, арчлах, хөрөнгө оруулалт хийж сайжруулах сонирхлыг бууруулдаг байна.

11. Тариалангийн талбайг өмчлөх асуудлыг тодруулах. Тухайлбал, одоо эзэмшиж байгаа тариалангийн талбайг он удаан жил ашиглаж ирсэн тариаланчдад нь давуу эрхээр үнэ төлбөргүй өмчлүүлэх талаар бодлогын хэмжээнд асуудал боловсруулах.

4.1.3. Хотын газар

1. Газрын харилцааны хүрээнд холбогдох бүх хууль, журам, тогтоолуудыг дахин шинэчлэж, боловсронгуй болгох

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ГЗБЕТ болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шаардлагын хэмжээнд боловсруулах эрх зүйн арга замыг нарийвчлан тогтоож хэрэгжүүлэх

Хотын газрыг барилгажсан ба барилгажаагүй гэж 2 хувааж, нийслэл дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгохоор хуулинд заасан нь газрын сангийн удирдлага алдагдахад хүргэсэн.

Үүнээс гарах арга зам нь олгох газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, орон нутгийн түвшинд газрын албаны тогтолцоо, ажил үүргийн хуваарийг шинэчлэн тогтоох явдал юм. Мөн аймаг, нийслэл, сум, дүүргүүд уг төлөвлөгөөг мэргэжлийн түвшинд боловсруулж чадахгүй байгаа нь газрын асуудал эрхэлсэн байгууллагуудын тогтолцоо буруу, ГЗБТ боловсруулах журам аргачлалгүй, түүнд оролцох мэргэжлийн ба салбарын байгууллагуудын эрх үүргийг нарийн хуульчлаагүйтэй холбоотой гэж үзэж байна. Газар олголтыг зөвхөн дүүргийн газрын алба хийх нь зүйтэй юм.

Мөн орон нутгийн газрын харилцааны байгууллагуудын ажил үүргийн хуваарилалтыг шинэчлэх хувилбар боловсруулах, Нийслэлийн газрын алба

болон дүүргийн газрын албаны үүрэг давхцаж байгааг дахин нягталж, тодорхой болгох шаардлагатай байна.

3. Газрын эдийн засгийн харилцаа үүсэхгүй байна гэж дүгнэж байна.

Хотын газар ашиглалтын гол алдаа дутагдал нь удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаа явдал гэж дүгнэж байна. Хот байгуулалтын хэсэгчилсэн төлөвлөгөө, ГЗБЕТ, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг олон нийтэд ил тод болгож, газар ашиглалтын харилцааг эрхлэн явуулж буй байгууллагуудын хоорондын зөрчлийг илрүүлж, хариуцлага хүлээлгэдэг байгууллагатай болгох хэрэгтэй.

Тав. Эрдэм шинжилгээ-практикийн бага хурал зохион байгуулсан талаар

Эрдэм шинжилгээ-практикийн бага хурал нь “Байгаль 21” ТББ-аас төслийн хүрээнд явуулсан судалгааны мониторингид мэргэжлийн экспертүүдийн өгсөн дүгнэлтийг хэлэлцүүлэх, Газрын мэргэжлийн байгууллага болон уг салбарын эрдэмтдийн үзэл бодлыг сонсох, цаашид газрын шинэтгэлийг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал бодлоо солилцох, мониторингийн дүн шинжилгээний материалаар эмхтгэл бэлтгэж зөвлөмж гаргах зорилготой хийгдсэн юм.

5.1. Бага хурлын илтгэлүүдээр эмхтгэл бэлтгэж, зөвлөмж гаргах

5.2. Төслийн явц, үр дүнгийн талаар сонинд нүүр гаргах

2005 оны 2-р сарын 7-ны өдөр Мэдээлэл технологийн үндэсний паркад ННФ-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн явц, үр дүнгийн талаар “Газрын харилцааны шинэтгэлийн мониторинг” эрдэм шинжилгээ-практикийн бага хурал зохион байгууллаа.

Бага хуралд УИХ-ын гишүүн Ж.Наранцацралт, УИХ-ын Байгаль орчны байнгын хорооны дарга Ч.Раднаа, УИХ-ын Байгаль орчны байнгын хорооны зөвлөх Д.Мягмарсүрэн, БОЯ, БХБЯ, МУИС, ХААИС, нийслэлийн газрын алба, ГХГЗЗГ, газар зүйн хүрээлэн зэрэг байгууллагын төлөөлөгчид, хэлтсийн дарга нар, эрдэмтэн докторууд, УБ хотын ерөнхий дендрологич Б.Чимид болон радио, телевиз, хэвлэлийн сурвалжлагчид оролцлоо.

Хурлыг “Байгаль XXI” ТББ-ын тэргүүн докторант Ж.Осоржамаа нээж төслийн явц, үр дүнгийн талаар танилцууллаа.

Хуралд дараах сэдвээр илтгэлүүд тавигдлаа. Үүнд:

1. Газрын харилцааны өнөөгийн байдал, түүнийг боловсронгуй болгох шаардлага
2. Бэлчээр ашиглалтын уламжлал шинэчлэлийн тулгамдсан асуудлууд түүнийг шийдвэрлэх арга зам
3. Нийслэл хот, түүний орчмын газрын харилцааны тулгамдсан асуудлууд түүнийг шийдвэрлэх арга зам
4. Монгол орны газрын сангийн мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох нь
5. Уул уурхайн үйлдвэрлэлээс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга зам
6. ТХГН-ийн газар ашиглалтын олон улсын жишиг, хандлага, Монгол орны онцлог
7. Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын асуудалд
8. Нийслэл хотын гэр хорооллын орчны төлөв байдал, түүнийг сэргээн сайжруулах асуудал
10. Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал
11. Мэргэшсэн боловсон хүчний чадавхийг бий болгох
12. Хотын газар ашиглалтын кадастр
13. Газрын хууль тогтоомжийн нэр томъёог боловсронгуй болгох нь зэрэг болно.

Эрдэм шинжилгээ-практикийн бага хурал дээр тавигдсан илтгэлүүдийг нэгтгэн эмхтгэл бэлтгэн хэвлүүлж, зөвлөмж бичиж гаргалаа. Мөн “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн явц, үр дүнгийн талаар “Монголын мэдээ” сонинд нүүр бэлтгэж гаргалаа.

Семинарын явцын талаар Монголын радио, “Монголын мэдээ”, “Зууны мэдээ” сонин, Монцамэ агентлагуудаар тус тус мэдээллээ.

5.1. Бага хурлын илтгэлүүдээр “Газрын шинэтгэлийн мониторинг” эмхтгэл бэлтгэж, зөвлөмж гаргав.

5.2. Төслийн явц, үр дүнгийн талаар “Монголын мэдээ” сонинд нүүр гаргав.

Зургаа. Хавсралт

6.1. Газар ашиглалтын чиглэлээр боловсруулсан “Кейс судалгаа”

6.1.1. ТХГН-ийн газар ашиглалтанд хийсэн “Кейс судалгаа”

6.1.2. Хотын газар ашиглалтанд хийсэн “Кейс судалгаа”

6.1.1. ТХГН-ийн газар ашиглалтанд хийсэн “Кейс судалгаа”

1. Зайсангийн амны онцлог:

Зайсангийн ам нь Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын /Богдхан уул БО-ны сайдын 1992 оны 05 тоот тушаалаар/ бүсэд хамрагддаг ба нийслэлийн Хан уул дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт оршдог, аж ахуйн нэгж, айл өрхийн суурьшил хамгийн их төвлөрсөн учир ТХГН-ийн газар ашиглалтын чиглэлээр кейс судалгаа хийхээр сонгон авсан болно.

2. Кейс судалгаа хийх шалтгаан, үндэслэл:

Зайсангийн аманд 662 өрх айл, 3862 хүн ам оршин суудаг, уламжлалт мал аж ахуй эрхэлдэг айл өрхүүд, хүүхдийн шорон, ХААИС, Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, ардын эмнэлэг, аялал жуулчлалын бааз, картингийн төв, улсын төв агропарк, зэргээс гадна сүүлийн үед гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд том том хашаа хатгаж, барилга байшин олноор барих болсон, мөн Туул голын эргээр айл өрхөөс гадна аялал жуулчлал амралтын зохиулалтаар олон цогцолборууд баригдаж, голын ус болон байгаль орчныг бохирдуулах зэргээр ТХГН-ийн тухай болон газрын хуулиудын зөрчил хамгийн их гардаг болсоныг харгалзан үзсэн болно.

3. Хууль эрхзүйн орчин:

Зайсангийн амны Дархан цаазтай газрын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ТХГН, байгаль хамгаалах, усны болон газрын хуулиуд, бусад тогтоол журмуудыг мөрдөн хэрэгжүүлэх ёстой.

Ялангуяа ТХГН-ийн хуулийн 7.33.1-д “Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно” гэж заасан байдаг.

4. Кейс судалгаа:

ТХГН болон газрын хуулиудын хэрэгжилтийн явцыг судлах зорилгоор энэ объектыг сонгон авч судалгаа явуулахад 2004 оны байдлаар 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллага газар ашиглаж, үйл ажиллагаа явуулдаг. Үүнд: “Элэгний уламжлалт эмчилгээний эмнэлэг”, ХААИС, Хүүхдийн хорих газар, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, ЕБ-ын 32-р сургууль зэрэг Хуулийн дагуу ТХГН-т газар ашиглах зөвшөөрөлтэй байна. Гэвч зарим аж ахуйн нэгж, байгууллагууд БОЯ-ны зөвшөөрлөөр газар ашиглаж, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа нь судалгааны явцад илэрсэн юм. Үүний нэг нь Уулын модны хаяанд, цэвэр устай булгийн эхэнд байгуулсан “Талын Монгол” ХХК-ий харьяа жуулчны бааз бөгөөд булгийн дээд талд жорлонгоо байрлуулсан, жуулчдад үйлчлэх наад захын шаардлагыг хангаагүй, Хөвсгөл аймгаас орж ирсэн адуун сүргийг бэлчээж хөрсийг талхалсан, гүү барьсан, газрыг ухаж сэндийлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн юм.

1999 онд байгаль орчны сайдын 136 тоот тушаалаар шинээр аж ахуйн нэгж байгуулах, газар олгохыг зогсоож, байгаль орчныг хамгаалах зорилгоор зайлшгүй шаардлагатай зарим нэг үйл ажиллагаа, тухайлбал Мэдээлэл сурталчилгааны төв, Хяналт шинжилгээний цэг, Экологийн боловсрол, сургалтын төв, Нийтийн амралтын үйлчилгээний түр цэг зэргийг ажиллуулж болохыг тусгай чиглэлээр баталгаажуулжээ. Энэ үед Зайсангийн аманд газар ашиглах зөвшөөрөлтэй 17 аж ахуйн нэгж, байгууллага байсан байна.

Гэтэл 136 тоот тушаалыг БО-ны сайдын 2001 оны 218 тоот тушаалаар хүчингүй болгосноор газар олголтын асуудал замбараагүйтэж, Зайсангийн амны айл өрх, аж ахуйн нэгжийн тоо жилээс жилд нэмэгдсээр одоо ямар ч зохицуулалтгүй болж, томоохон барилга байгууламжууд хоног дараалан босох болжээ. Үүний жишээ нь ХААИС-ийн биеийн тамирын талбайн орчинд Хатантуул цогцолбор, зүүн талд нь “Цаст” констракшн, мөн “Магнай трейд” ХХК-ууд хашаа барьж, барилгын суурь ухаж байна.

ТХГН-т газар ашиглах гэрээний хугацаа 5 жилээс илүүгүй байдаг. Гэтэл 11-р хорооны нутаг дэвсгэрт буй айл өрхүүд ихэвчлэн 10-аас дээш жил суурьшсан, зарим хэсэг нь ямарч зөвшөөрөлгүй оршин сууж байгаа юм. Мөн хорооны засаг дарга, зохион байгуулагч болон байгаль хамгаалагч нар нь дур мэдэн газрын зөвшөөрөл өгч, айл буулгадаг байна.

Судалгаа хийх явцад Зайсан толгойн зүүн уулын энгэрт 1,5 га орчим талбай бүхий хашааг босгосон, тэндхийн ард иргэд Солонгосын хөрөнгө оруулалттай компани ямар нэгэн цогцолбор барих гэж байгааг ярьцгааж байв.

Мөн “Петровис” ХХК-ий карпингийн төв, Солонгос эмчийн хөшөөтэй цэцэрлэг байгуулснаас гадна Есүсийн сүм зэргийг барьж байгаа юм байна.

Зайсан толгойн зүүн хойно хуучин хүүхдийн халдвартын эмнэлэг байсан барилгыг Солонгосын компани худалдан аваад 3-4 жил болж байгаа, энд нууц казино байгуулсан гэж оршин суугчид ярьж байлаа. Энэ нь Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг зөрчсөн үйлдэл болсон байна.

Зайсан толгойн зүүн талд 6-7 айл шинээр хашаа хатгаж суурьшсаныг сонирхвол дэлгүүрийн хажуугаас хөөгдөөд энд буусан, Алтангэрэл, Аюурсэд нарын зэрэг хашаатай болон хашаагүй айлууд 10-аад жил амьдарч байгаа аж.

Зайсан толгойн өмнөх агропаркийн баруун талд болон ХААИС-ийн туршлагын талбайн орчимд хэд хэдэн том хашаа босгосон нь “Сапу” ХХК-ийн Японтой хамтарсан конференц заал баригдах газар юм байна.

ХААИС-ийн оюутны байрны баруун талаар байгаа гэр хорооллын орчмыг 5-р хэсгийн задгай гэж нэрлэдэг бөгөөд энд 130 орчим айл 2-6 жилийн хугацаагаар амьдарч байгаа юм байна. Богд хан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга М.Гомбодоржийн нэхэмжлэлтэй Хан уул дүүргийн шүүхэд гаргасан өргөдлийн дагуу нэр бүхий 15 айлыг нүүхийг шаардаж хөөсөн ба шүүхэд дуудаж мэдэгдэл өгсөн байна. Ер нь тэнд оршин суугчид Дархан цаазат газарт айл өрх байлгахгүй гэдгийг ухамсарласан, нийт хүмүүст жигд шаардлага тавьж нүүлгэвэл зөвшөөрөх хандлагатай байгаа нь ажиглагдсан юм.

Зайсангийн амны иргэдээс авсан судалгаанаас үзэхэд олонхи нь 4 ба түүнээс дээш жил амьдарч байгаа буюу энэ нутгийн унаган иргэн бөгөөд байгаль, агаар сайхантай учир амьдрах сонирхолтой байдаг, ТХГН-т газар эзэмшиж, удаан хугацаагаар ашиглах эрх байхгүй тул нутгийн иргэдийн эрх ашиг хохирч байна гэж хариулсан байна. Хуулийн хэрэгжилтийн талаар тэд хэрэгжих нөхцөл бүрдээгүй байсан, үндсэн хууль болон хүний эрхийг зөрчиж байна, газар ашиглах гэрчилгээ олгоход чирэгдүүлж байна, даац нь хэтэрчихээд байхад газар нэмж олгодог, Хамгаалалтын захиргаа хууль зөрчсөн үйлдэл олныг явуулж байна, өндөр албан тушаалтан, түүний хамаатан садан газрыг голчлон авч байна, ТХГН-т газар ашиглалтыг Газрын тухай хуулиар зохицуулах нь зүйтэй гэсэн хариултыг голдуу өгсөн байлаа. БОЯ-наас газар ашиглах гэрчилгээ авсан болон гурвалсан гэрээ байгуулсан нь цөөн, харин зөвшөөрөлгүй амьдарч, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага олон байв. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй, ТХГН-т газрыг аялал жуулчлалын зориулалтаар голчлон ашиглаж

байгаа нь судалгаагаар ажиглагдсан бөгөөд уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхлэх, өөр зориулалтаар үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэн, аж ахуйн нэгж ч байлаа.

Энд газар ашиглаж, үйл ажиллагаа явуулж буй томоохон байгууллага болох ХААИС нь оюутны цогцолбор /кампус/ барихаар БОЯ, ХХААЯ, Боловсролын яамны шийдвэр гарч, гурвалсан гэрээ байгуулсан боловч одоо болтол гэрчилгээ өгөөгүй байна. Гадаадын их, дээд сургуулиуд ихэнх нь ууланд, оюутны сурч, амьдрах бүхий л орчныг бүрдүүлсэн байдаг. Манай улс ядаж ганц үлгэр жишээ оюутны цогцолбортой байх хэрэгтэй бөгөөд хотын бусад сургуульд газрын боломж байхгүй учир энд 10 000 оюутны үйлчилгээний цогцолбор барьчихвал бусад сургуулийнхан ч ирж үйлчлүүлэх боломжтой юм.

ХААИС Улсын төв агро паркийг 10 жилийн өмнө сэргээн жимсний мод тарьж, 60 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийсэн боловч 2004 оны намар БОЯ-наас 3 хоногийн дотор талбайг чөлөөлж нүү гэсэн шаардлага тавьсан нь эрдэм шинжилгээний зориулалтаар газар ашиглаж болно гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхгүй байгаа жишээ юм.

5. Дүгнэлт:

1. Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаа нь тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах, явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих, ТХГН-ийн ач холбогдол, хамгаалалтын горим, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоох үндсэн үүргээ биелүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна.

2. ХУД-ийн 11-р хорооны засаг дарга, хорооны зохион байгуулагч болон байгаль хамгаалагч нар дур мэдэн газрын зөвшөөрөл өгч, айл буулгадаг нь ТХГН-т газар ашиглах гэрээний хугацаа 5 жилээс илүүгүй байна, тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрын хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээний дотор хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг дарга тогтооно гэсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

3. БОЯ зарим иргэн, аж ахуйн нэгжүүдэд газар олгосон нь ТХГН-ийн болон байгаль орчны хуулийн хэрэгжилтийг хянах ёстой үүргээ умартаж, хууль зөрчсөн үйлдэл болсон байна.

6. Санал зөвлөмж:

1. Богдхан уулын Дархан цаазат газар Зайсангийн аманд газар олгохыг хориглосон Байгаль орчны сайдын 1999 оны 136-р тушаалыг сэргээж шинэчлэн төрөл бүрийн зориулалтаар баригдсан барилга байгууламжуудыг нүүлгэн шилжүүлэх, татан буулгах замаар газраа чөлөөлж авах ажлыг Байгаль орчны яам, хамгаалалтын захиргаад ойрын үед зохион байгуулах арга хэмжээ авах

2. ТХГН-т амьдарч, үйл ажиллагаа явуулж байгаа албан тушаалтан, иргэдээс тавьж байгаа саналыг үндэслэн ТХГН-д газар ашиглах зарим заалт, хэсгийг өөрчлөн найруулж, нутгийн унаган иргэдийн амьдрах орчныг хангаж өгөх

3. ТХГН-т явуулах аялал жуулчлалын талаар ТХГН-ийн тухай хуульд “ТХГН-т явагдах аялал жуулчлал” гэсэн нэг бүлэг нэмж оруулах

4. Газрын тухай хууль, ТХГН-ийн тухай хуульд ТХГН-т газар эзэмших, өмчлөх харилцааг зохицуулах зорилгоор “ТХГН-т газар ашиглах, судалгаа шинжилгээний ажил явуулах” гэсэн 7 дугаар бүлгийг шинэчлэн ТХГН-т газар ашиглах, эзэмших, өмчлөх харилцааг тодорхой тусгаж өгөх

5. Газрын тухай хуульд “ТХГН-т газар ашиглуулах, эзэмших, өмчлөх асуудлыг ТХГН-ийн тухай хуулиар зохицуулна гэсэн нэмэлт өөрчлөлт оруулах замаар ТХГН-т газар ашиглуулах асуудлыг нэг мөр болгож шийдвэрлэх

6. ТХГН-ийн хамгаалалтын захиргааны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын зүгээс хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг хүчтэй болгож, зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу шийтгэл ногдуулж, хариуцлага тооцдог болгох, ажлын хариуцлагыг дээшлүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах

7. Байгаль орчны яам болон эрх бүхий байгууллага ТХГН-ийн тухай хуулиар хориглосон ашигт малтмалын хайгуул хийх, ан амьтан барих, аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар барилга байгууламж барих зөвшөөрлийг хуулийн дагуу олгохгүй байх

8. ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажилтнууд, сум, дүүргийн Засаг дарга нар ТХГН-т хууль зөрчин газар ашиглуулах зөвшөөрөл олгодогийг цаашид бүрмөсөн зогсоож, хуулиа дээдлэн, хуулийн хүрээнд ажиллах

6.1.2. Хотын газар ашиглалтанд хийсэн “Case study”

1. Гацуурт тосгоны онцлог:

Засаг захиргааны зохион байгуулалтаар Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт харъяалагддаг тул хотын газарт хамрагдах боловч нийслэлээс 27 км зайтай оршдог, эрчимжсэн мал аж ахуй хөгжсөн, хүнсний ногоо тэжээлийн ургамал тариалдаг, аялал жуулчлалын үйл ажиллагаа хөгжиж буй, нийслэлийн ногоон бүсэд багтдаг /УБ хотын цэвэр усны эх ундарга дээр оршдог/ зэрэг онцлог талуудтай учраас хотын газар ашиглалтын чиглэлээр хийж буй кейс судалгаанд сонгож авсан юм.

2. Кейс судалгаа хийх шалтгаан, үндэслэл:

Тус тосгон нь 1700 өрх, 6200 хүн амтай, 30 000 толгой малтай, 77 000 га нутагтай. Голдуу гэр хороолол суурьшсан, сүүлийн жилүүдэд ойрын болон холын аймгуудаас малгүй болсон айл өрхүүд олноор нүүж ирсэн, мөн нийслэл хотын айл өрхүүд ч газар авч хашаа барьж байгаа зэргээс шалтгаалан хүн ам болон малын тоо толгой олширч, нягтрал нь ихэссэн, байгаль хамгаалах ба газрын хуулийн зөрчил олон гардаг, үүнээс болж байгалийн унаган төрх алдагдаж даац нь хэтэрч байгаа зэргийг харгалзан үзсэн болно.

3. Хууль, эрхзүйн орчин:

Гацуурт тосгоны онцлогоос шалтгаалан энд МУ-ын олон хууль, тогтоомжууд мөрдөгддөг. Үүнд: “Байгаль хамгаалах тухай хууль”, “Усны тухай хууль”, “Газрын тухай хууль”, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” зэрэг болно .

4. Кейс судалгаа:

Гацуурт тосгоны төв болон гэр хороолол нягт суурьшсан Гацууртын ам, Хуандай, Дээндий, Шар хоолойн амууд, Хужир булан, Могойт дэнж, Туул голын эрэг, голдирлын дагуу явж, малтай, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалдаг, фермерийн аж ахуй эрхэлдэг ард иргэд болон тосгоны захирагч мөн байгаль орчны улсын байцаагч зэрэг хүмүүсээс мэдээлэл авч, газрын хуулиудын хэрэгжилт ямар байгааг мэдэх зорилгоор судалгаа хийлээ.

Тус тосгонд хашааны газраа эзэмших ажил нилээд сайн явагдаж буй сайн талтай боловч газар өмчлөлийн ажил эхлээгүй байсан нь айл өрхийн хашааны газрын кадастрын зураг хийгдэж дуусаагүй хүлээгдэж байгаатай холбоотой байлаа.

Газар өмчлүүлэх ажил хэрхэн явагдаж байгаа талаар иргэдээс судалгаа авахад нийт 833 иргэн 1135 хашааны газар өмчлөх ёстойгоос 507 иргэн 101.14 га газар өмчлөхөөр хүсэлт гаргасан байна.

Газар дээр нь явж судалгаа хийхэд нийт оролцогчдын олонхи нь хашаа, орон сууцны зориулалтаар газраа эзэмшдэг, 5 ба түүнээс дээш жилээр оршин сууж байгаа, дүүргийн газрын албанаас газар эзэмших гэрчилгээ авсан нь харагдлаа. Эрх мэдэлтэй, мөнгөтэй хүмүүс том хашаа эзэмшиж, зам бэлчээрийг боож байна, иргэнд газрыг өмчлүүлэх нь зүйтэй байна, шинээр өрх тусгаарлаж буй хүмүүст газрыг үнэ төлбөргүй өгөх хэрэгтэй, хуучин ногоон тэжээлийн талбайг ашиглаж буй хүмүүсийн олонхи нь гэрээ хийдэггүй, төлбөр төлдөггүй, дураараа ашиглаж байгааг болиулж, хуулийн дагуу зохицуулах шаардлагатай байна гэсэн гомдол, санал хүсэлтүүдийг тавьж байлаа. Гэвч зарим иргэд ямар ч зөвшөөрөлгүй оршин суудаг, Өргөдөл хүсэлтээ гаргасан боловч гэрчилгээгээ авч чадаагүй айл өрх нилээд байв. Олонхи нь цаашид байнга хашаандаа амьдран сууж үр хүүхдэдээ өвлүүлэх хүсэлтэй ба газраа банкинд барьцаалж зээл авах бодолтой иргэд байгаа боловч бүтэх эсэх нь эргэлзээтэй гэсэн яриатай хүмүүс ч байсан юм.

Мөн газар эзэмшлийн гэрчилгээг авах материалаа дүүрэг рүү өгч явуулаад хариу нь удаж ирдэг, Нийслэлээс эрх мэдэлтнүүдийн цохолтоор тэдний найз нөхөд, хамаатан саднууд эндээс газар авах нь ихэссэн, зарим иргэд дур мэдэн хашаа хатгаж байгаа зэрэг зөрчлүүд гардаг ажээ.

Газраа эзэмших өргөдөл гаргаж, гэрчилгээ авахад хир хүндрэл учирч байгааг судлахад дүүргийн болон хорооны засаг дарга, хот байгуулалтын архитекторуудын үйл ажиллагаа хөшүүн хойрго, төрийн албан хаагчид нь соёлгүй харьцаатай, хүнд сурталтай, ялангуяа техникийн нөхцөл бүрдүүлж, холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авах, гэрчилгээ олгоход шат дамжлага олонтой байдаг, 6-8 сар хөөцөлдөж байж асуудлаа шийдүүлсэн, гол нь захирамж шийдвэр гаргуулах, газрын гэрээ байгуулж, гэрчилгээ олгох нь үе шат нь хүндрэлтэй байгаа нь ажиглагдсан.

Гацуурт тосгон нь хот орчмын эрчимжсэн МАА-г хөгжүүлэх малын бэлчээрийн нөөц газрын нэг. Энд ихэвчлэн мал аж ахуй болон фермерийн аж ахуй эрхэлдэг айл өрхүүд амьдардаг ба сүүлийн үед хотоос болон ялангуяа баруун аймгуудаас малгүй болсон айл өрхүүд олноор ирж суурьшин хүн амын нягтрал эрс нэмэгдэж байна. Энэ нь нийслэлийн цэвэр усны эх үүсвэрийг бохирдуулж, Туул голын ай савын хамгаалалтын дэглэмийг алдагдуулж байгаа байдал ажиглагдлаа.

Бэлчээрийн хүрэлцээ, төлөв байдлын талаар судалгаа явуулахад хүн, мал нэг дороо хэт төвлөрснөөс болж ойрын бэлчээрийг их талхалж байна, Үр

цацах, услах, бордох, өнжөөж ашиглах зэрэг нөхөн сэргээх зориудын арга хэмжээ авч бэлчээрийг хуваарьтай ашиглах нь зүйтэй, бэлчээр ашиглалт ямарч зохицуулалтгүй урсгалаараа явж байгааг зогсоож, дүүрэг хорооны ИТХ-аар хэлэлцэн зохицуулах шаардлагатай болох нь харагдсан юм.

Нөөц бэлчээр байсан ч зундаа гол үерлээд мал гаргадаггүй, өвөлдөө бол хад асга ихтэйгээс мал нь ууландаа гарч бэлчиж чаддаггүй хүндрэл байдаг ба сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо нэмэгдэж, зөвхөн баруун аймаг биш ойрын аймгуудаас айл өрхүүд нүүн ирж байгаа нь бэлчээр талхлагдаж доройтох, бэлчээрийн даац хэтрэхэд ихээр нөлөөлж байгаа юм байна.

Засгийн газрын тогтоолоор энд аялал жуулчлалын бүс, эрчимжсэн мал аж ахуй эрхэлнэ гэсэн заалтын дагуу Монгол шилтгээн, Говь ХХК-ийн салбар амралт, УБ сувиллын харьяа амралт, улирлын чанартай ажилладаг 30-аад амралт зэрэг аялал жуулчлалын газрууд ажилладаг байна.

Сүүлийн үед газар эзэмшүүлэх ажил ахицтай явагдаж буй юм байна. Голын эргийн айлуудад өвөлжөөг эзэмшүүлэх гэрээ хийгдэж, төвд 300 өрхөд газрыг нь эзэмшүүлжээ. Уулын амуудад зураг хийлгэх асуудлыг тавьсан байна. Газрын хууль гарснаас хойш газарлуу хандах хүмүүсийн сонирхол ихэссэнийг Могойт дэнж, Хар усан тохойд сүүлийн үед 6-7 жилд дээрээс шийдвэртэй том том хашаа олон баригдсан, хүн малын урсгал энэ тийш чиглэсэн зэргээс харж болохоор байлаа.

Гацуурт тосгон УБ хотын цэвэр усны эхэн дээр байрладаг учраас энд буй олон жорлон, муу усны нүх, химийн бордоо нь ариун цэвэр, эрүүл ахуйд сөргөөр нөлөөлж, хөрсний бохирдол ихсэж байна. Голын доогуур байгаа 100 гаруй айл хашаандаа ногоо тарьдаг. Иргэд албан ёсоор жимс, ногоо тарих талбай өмчилж авах хүсэлтэй байдаг ч энэ асуудал яаж шийдэгдэх нь тодорхойгүй байна.

5. Дүгнэлт:

Гачуурт тосгонд газар хувьчлалын ажлыг явуулахад тохиолдож байгаа гол бэрхшээл бол энэ асуудлаар тосгоны захиргаа ямарч эрх мэдэлгүй байгаа явдал бөгөөд Тосгоны захирагчийн алба газар өмчлүүлэх тодорхойлолт гаргаж, дүүргийн захиргаан дээр газар олгох асуудлыг шийдвэрлэдэг нь шат дамжлагыг нэмэгдүүлж, ард иргэдийг хот руу байнга явуулж чирэгдүүлэх нөхцөл болж байна. Дүүргийн газрын мэргэжилтэн тосгон дээр байнга ажиллаж чаддаггүйгээс болж газар олголтонд Нийслэл, дүүргийн захирамж давхцах явдал байнга гардаг байна.

БЗД-ийн 20-р хороо, Гацуурт тосгон нь гурван сумын хэмжээний хүн амтай, нэг сумын хирийн нутагтай ажээ. Иймээс Газар өмчлөлийн ажлыг замбараатай явуулахын тулд тосгон бие даан ажиллаж, сумын даамлын хэмжээнд газраа хөөцөлддөг газар зохион байгуулагчийг суурин ажиллуулах шаардлагатай байгаа нь харагдлаа.

Энэ талаар УИХ-ын гишүүн Ц. Мөнх-оргил болон хот дүүрэгт ИТХ-д нэр дэвшсэн хүмүүст санал хүсэлт тавьсан ажээ. Дүүргийн удирдлагын ажил тосгонд бүрэн хүрдэггүйгээс дунд нь ажил цалгардаж, хариуцлага орхигддог учраас газар олголтыг тосгоны удирдлага шийдвэл хариуцлага, хяналт сайжрах боломжтой гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

6. Санал зөвлөмж:

А. Гацуурт тосгонд цаашид хүн ам, мал сүрэг нэмэгдэх магадлалтай учир орон тооны газрын даамал ажиллуулах

Б. Иргэний бүртгэл, татварын хэлтэс, газар өмчлөл зэрэг бусад олон асуудлыг газар дээр нь үзэж, шуурхай хэрэгжүүлэх, үнэн зөв шийдэх, хяналтыг сайжруулах зорилгоор тосгоны удирдлагад тодорхой эрх мэдлийг олгох

В. Хүн амын нягтралыг шийдэх бодлогыг яаралтай боловсруулж, орон нутгийн байгаль орчин болон бусад дэд бүтцийн ачааллыг харгалзан суурьших хүн амын тоог бодитой тогтоох

Г. Байгаль хамгаалагч болон цагдаагийн ажлын үзүүлэлтэнд байгаль орчноо хамгаалах, зөрчлийн хойноос хөөцөлдөх зэрэг заалтууд оруулж, хамтын ажиллагааг нь сайжруулах, ажлыг нь дүгнэж урамшуулах, машин, бусад техник хэрэгслээр хангах асуудлыг шийдвэрлэх

Д. Ногоон бүсийн газар ашиглалт, эзэмшлийг зохицуулах хууль эрх зүйн орчныг бий болгох

Е. Хот орчмын ногоон бүсийн харуул хамгаалалт, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар өнөө үед тохирсон захирамж гаргаж хэрэгжүүлэх

Ж. Гацуурт тосгоны газрын зургийг шинээр гаргаж, зохих албан тушаалтанд гарын авлага болгон тарааж өгөх

6.1.3. ТХГН болон хот суурины чиглэлээр хийсэн “Кейс судалгаа”-нд хамрагдсан объектын газар ашиглалтын зөрчлүүд

Хүснэгт 1

	<i>Зөрчигдөж буй хуулийн</i>	<i>Объектын нэр,</i>	<i>Шийдвэрлэсэн</i>	
--	------------------------------	----------------------	---------------------	--

№	нэр, зүйл, заалтын дугаар, утга	байршил, хэмжээ, зориулалт	байгууллагын нэр, шийдвэрийн дугаар	тайлбар
Нэг. Богдхан уулын Зайсангийн ам				
1.	ТХГН-ийн тухай хуулийн 11.7 ба 12.5-д /аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар/ зааснаас өөр барилга байгууламж барихыг хориглоно;	-Мэдээлэл сурталчилгааны төв -Хяналт шинжилгээний цэг -Экологийн боловсрол, сургалтын төв - Нийтийн амралтын үйлчилгээний түр цэг зэрэг үйл ажиллагаа явуулж болохыг тусгай чиглэлээр баталгаажуулжээ	1999 оны байгаль орчны сайдын 136 дугаар тушаалаар	Шинээр аж ахуйн нэгж байгуулах, газар олгохыг зогсоож, байгаль орчныг хамгаалах зорилгоор зайлшгүй шаардлагатай зарим нэг үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглосон юм. .
		ХУД-ийн 11-р хороог шилжүүлж, айл өрхийг нүүлгэх, Зайсангийн автобусыг ХААИС-аас цааш явуулахыг зогсоож, нэвтрэх цэг байгуулж ажиллуулах шийдвэр гаргасан байна.	“Богдхан уулын ДЦГ-ын Зайсангийн амны хамгаалалтыг сайжруулах тухай” 200.. оны БО-ны сайдын ..р тушаалаар	200.. онд Зайсангийн аманд үйл ажиллагаа явуулж, хамгаалалт хяналтын ажлыг гүйцэтгэхээр “Элэгний уламжлалт эмчилгээний эмнэлэг” урт хугацааны хөрөнгө оруулалтын гэрээ байгуулан ажилласан байна.
		Зайсангийн амыг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг хэд хэдэн яам хамтарч гаргахаар ажилласан боловч тэр төлөвлөгөө нь өнөө хир “нууц” байна	2003 онд БОЯ, Санхүү-эдийн засгийн яам, Боловсролын яамнаас тусгай комисс байгуулагдан ажилласан	2004 онд Богдхан уул түүн дотроо Зайсангийн амыг онцлон үзэж байгаль орчны төлөв байдал, даацын үнэлгээ хийхээр БО-ыг хамгаалах сангаас 60 сая шахам төгрөгийн төсөв батлуулан ажиллажээ
2.	ТХГН-ийн тухай хууль 11-р зүйл. 7/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох... зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах;	Зайсангийн амны урд	БО-ны сайдын 1999 оны 136 тоот тушаалыг БО-ны сайдын 2001 оны 218 тоот тушаалаар хүчингүй болгосноор	20-иод гэр нь аялагчид буудаллах эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй, УБ хотоос счдог өдрийн амрагчдын архидах газар болсон байв.

3.	Мөн хууль 2-р зүйл 1/ газар ухах... зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөхийг хориглоно;	мухарт 10 га орчим талбайд “Талын Монгол” ХХК Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг.	Зайсангийн амны айл өрх, аж ахуйн нэгжийн тоо жилээс жилд нэмэгдсээр одоо ямар ч зохицуулалтгүй болж томоохон барилга байгууламжууд хоног дараалан босох болжээ	Худаг гаргахаар газар ухаад дутуу орхисон байв.
4.	Мөн хууль 2-р зүйл 6/ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно;			Булгийн ундаргын дээд талд бие засах газар байрлуулж, орчныг бохирдуулсан байв.
5.	Мөн хууль 2-р зүйл 9/... зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэхийг хориглоно;		Дээрхтэй адил	Хөвсгөл аймгаас ирсэн сүрэг адууг бэлчээж хөрсийг талхлан, модноос морь уяж, гүү барьсан байсан
6.	Мөн хуулийн 33-р зүйл. 2/ гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно.	Улсын төв агро паркийн зүүн талын модон барилгад Солонгосын талтай хамтарсан “Сю нөхөрлөл” Христийн сүмийн үйл ажиллагаа явуулдаг	Дээрхтэй адил	Мөн орчны газрыг ашиглаж ногооны талбай болгосон байна.
		Улсын төв агро паркийн талбайд Сапу ХХК Японтой хамтарч конференцийн заал барихаар болсон аж.	Дээрхтэй адил	Сапу ХХК уг газрыг худалдан авч, ХААИС-ийн байгуулсан төв агро парк талбайгүй болж буй юм байна.
		Зайсан толгойн зүүн урд талын энгэрт 1.5 га талбайтай шинэ хашаанд Солонгосын хөрөнгө оруулалттай цогцолборын барилга баригдана	Дээрхтэй адил	Энэ хашааны сахиул нь ямар компанийх болохыг хэлээгүй ч солонгосын хөрөнгө оруулалттай барилга баригдана гэж ард иргэд мэдээлэл өгсөн
		Зайсан толгойн зүүн хойд талд хуучин хүүхдийн халдвартын эмнэлэг байсан барилгад солонгос айлууд 3-4 жил амьдарч байна.	Дээрхтэй адил	Солонгосын компани худалдаж авсан, Нууц казино ажилладаг гэж ард иргэд ярьж байна.
Зайсан толгойн замын ар талд Туул голын эрэгт Солонгос эмчийн цэцэрлэг баригдсан	Дээрхтэй адил	Цаашид энд ямар үйл ажиллагаа явуулах нь тодорхойгүй байна.		

7.	12. 5/ 11.7/-д /аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар/ зааснаас өөр барилга байгууламж барихыг хориглоно;	ХААИС-ийн Биеийн тамирын талбайд “Голден ийгл хауз” ХХК-ий орон сууцны “Хатантуул цогцолбор”, Зүүн талд нь “Мафекс” ХХК-ий Залуучуудын амралт зугаалгын төв- зочид буудал-орон сууцны цогцолбор, Мөн “Сарнайх” ХХК-ий аялал жуулчлалын цогцолборын барилга баригдаж байна.	Дээрхтэй адил	Эдгээр барилга нь ерөнхий сайд Н.Энхбаярын ээж Бүдхандын оролцоотой газрын зөвшөөрөл авч, баригдаж байна гэж 11-р хорооны иргэд, ХААИС-ийн оюутнууд мэдээлж байна.
		Танктай хөшөөний зүүн талын “Хатантуул цогцолбор”-ын 2-р ээлжийн барилга баригдахаар болжээ.	Дээрхтэй адил	Дээд газрын найдвартай зөвшөөрөлтэй учир 3 хэсэгт барилга барьж байна.
		Зайсан толгойн баруун талд засмал замын дагуу халаалтын болов бохир усны хоолой тавих хавтан буулгаж траншей ухсан	Дээрхтэй адил	“Хатан туул” цогцолборын залуучуудын орон сууцны барилгын халаалтын, бохир усны хоолой тавих траншей гэж иргэд мэдээлэв.
		Зайсан толгойн дэлгүүрийн урд талд “Вертикаль” ХХК барилга барих том хашаа шинээр барьсан	Дээрхтэй адил	Эдгээр мэдээллийг тэнд амьдардаг иргэд өгсөн болно.
		Зайсан толгойн баруун урд талаар Залуучуудын орон сууцны цогцолбор баригдаж байна.	Дээрхтэй адил	“Хатан туул” ХХК-ий Амралт үйлчилгээний цогцолборын нэг хэсэг гэж ард иргэд мэдээлэв.
8.		Зайсан толгойн ар талд Туул голын эрэгт “Жи Ди энд Би” ХХК-ий Картинг спортын төв ажилладаг	Дээрхтэй адил	“Жи Ди энд Би” ХХК-ий эзэмшлийн газар
9.	31-р зүйл. 2.1/ ТХГН-т ажиллаж байгаа байгаль хамгаалагч нь хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавих	ХУД-ийн 11-р хорооны нутаг дэвсгэрт багтах Зайсангийн аманд	Дээд байгууллагын ямар ч тушаал заавар, зөвшөөрөлгүй	Байгаль хамгаалагч нь хуулинд заасан гол үүрэгт ажлаа хийхийн оронд хууль зөрчиж, танил тал, ах дүүдээ дур мэдэн хашаа барих газар заан олгож байна.

10.	<p>үүрэгтэй; Хуулийн 7-р бүлгийн 33.1/“Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно” гэсэн нь газар эзэмших, өмчлөх эрх хязгаарлагдмал байдаг гэсэн үг юм.</p>	<p>ХААИС-ийн оюутны байрны зүүн талд /Энэ орчмыг 5-р хэсгийн задгай гэж нэрлэдэг бөгөөд/ 130 орчим айл 2-6 жилийн хугацаагаар амьдарч байгаа юм байна.</p>	<p>Айл өрхүүд ямар ч зөвшөөрөлгүй оршин суудаг учир Богд хан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга М.Гомбодоржийн нэхэмжлэлтэй ХУД-ийн шүүхэд гаргасан өргөдлийн дагуу нэр бүхий 15 айлыг нүүхийг шаардаж хөөсөн ба шүүхэд дуудаж мэдэгдэл өгсөн байна.</p>	<p>Тэнд оршин суугчид Дархан цаазат газарт айл өрх байлгахгүй гэдгийг ухамсарласан, нийт хүмүүст жигд шаардлага тавьж нүүлгэвэл зөвшөөрөх хандлагатай нь ажиглагдсан.</p>
11.	<p>30-р зүйл. 1/ТХГН-ийн талаарх хууль тогтоомж, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах; 10/ зөвшөөрөгдсөн бүсэд байлгаж болох малын төрөл, тоо болон зохих журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрыг тогтоох</p>	<p>Богд хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа</p>	<p>ТХГН-ийн тухай хуулийг зөрчиж байна.</p>	<p>Хуулийн дагуу эдгээр заалтыг мөрдөж ажиллах ёстой ч БОЯ нь өөрөө газар ашиглуулах зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжийг зөрчин олгодгоос болж, хамгаалалтын захиргаа үүргээ биелүүлж чадахгүйд хүрээд байна.</p>

Хоёр. БЗД-ийн Гацуурт тосгон

1.	<p>Газрын тухай хуулийн 27.4. эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хоргилоно.</p>	<p>Хуучин САА-н тэжээлийн ургамал тарьж байсан талбайд</p>	<p>Ямар ч албан ёсны гэрээ, шийдвэр, зөвшөөрөлгүй</p>	<p>Зарим хүмүүс 20-30 га талбайг хувьдаа эзэмшиж байна.</p>
2.	<p>30.1 газрыг 15-60 жилээр эзэмших эрхтэй</p>	<p>Тус тосгонд</p>	<p>НЗА-ны шийдвэрээр</p>	<p>иргэд 5 жил болоод л гэрээгээ сунгуулж, дахин материал бүрдүүлж, их мөнгө төлдөг байна</p>
3.	<p>МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 7.1.3-д сумын төв, тосгонд 0.5 хүртэл га газар өмчлүүлнэ</p>	<p>Могойт дэнж, Хар усан тохой, гацуурт тосгонд Сүүлийн 6-7 жилд олон том хашаа баригдсан.</p>	<p>дээрээс захирамжтайгаар</p>	<p>Уулын амыг бүтнээр нь хашсан, дураараа хашаа хатган, хашаагаа сунгаж хэмжээнээс илүү газар эзэмшиж байна.</p>
4.	<p>31.2-д Усны эх, ундаргад онцгой хамгаалалтын бүс тогтооно</p>	<p>сүүлийн үед голын дагуу айл олноор суурьшсанаас ахуйн хэрэглээний бохир ус гол руу орж, нийслэлчүүдийн үндны цэвэр усны эх</p>	<p>Онцгой хамгаалалтын бүс тогтоосон шийдвэр байхгүй</p>	<p>Гацуурт тосгоны дээд талаас Туул гол урсан орж ирдэг ба нийслэлийн цэвэр усны эх, ундарга учраас онцгой хамгаалалтын бүс</p>

		ундаргыг бохирдуулж байна.		болж байгаа юм..
5.	31.2.1-д онцгой хамгаалалтын бүсэд ... мод огтлох, элс хайрга, чулуу авах, мал угаах болон ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно	Туул голын эрэг, голдиролын дагуу айл өрхүүд олноор хашаа хатгаж буух болсон. Хужир булан Маршалын гүүрийн хооронд машинтай орж, элс шигших, айл өрхүүд голд ойрхон хашаа хатгаж буух, зарим иргэд, ААН-үүд амралт сувилал ажиллуулах зэрэг зөрчлүүд их гарч байна.	БОЯ буюу нийслэл, дүүргийн газрын албадын шийдвэрээр	хувийн орон сууц барих, машинтай иргэд Туулын голдрилоос мод огтолж ачих, элс чулууны чөнгүүд ирж чулуу болон элс, хайрга ачих явдал хэвийн үзэгдэл болжээ. Элс хайрга авсан газар нь хонхойж, мод авсан газрын гүний усны түвшин доошилж, Туул голын усны ширгэлтэнд ихээр нөлөөлж байна.
6.	31.3-д Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, 100м-ээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно	Голын эргийн дагуу айл өрхөд газар олгодог Хуульд зааснаар голын эрэгт ойрхон айл буух ёсгүй.	БЗД-ийн газрын албаны шийдвэрээр	Гэтэл иргэдэд газар өгдөг ба газар дээр нь очиж үзвэл үер болоход усанд урсах айл олон байгаа нь харагдлаа.
7.	34.2-д Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар доторлож тохижуулсан байна	Голын эх болон голдирлын дагуу буусан айл өрхүүд	Энэ байдалд нийслэл, БЗД, Гацуурт тосгоны захиргааны зүгээс тодорхой арга хэмжээ авахгүй өдий хүрсэн байна.	бодит байдал дээр айл өрхүүд бие засах газар болон муу усны нүхээ доторлохгүй байгаагаас бохир ус нь Туул гол руу урсан орж нийслэлчүүдийн ундны усыг бохирдуулан, эрүүл ахуйн дэглэмийг зөрчиж, хууль хэрэгжихгүй байна.
8.	37.1.8-д усыг бохирдохоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, эсхүл усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг 20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 хүртэл төгрөгөөр торгох ёстой	Гацуурт тосгонд	Энэ талаар БЗД болон тосгоны захиргаа, байгаль орчны улсын байцаагч нар хууль хэрэгжүүлэх талаар үүргээ биелүүлэхгүй байна.	хуулийн заалтыг биелүүлж, шаардлага тавьж, торгууль ноогдуулдаг албан тушаалтан алга байна.
9.	Ойн хуулийн 32.2. ойн санд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо бэлтгэж ашигласан модыг экологи-эдийн засгийн үнэлгээгээр нь	Хужирбуланд болон голын дагуух хэсгүүдэд	ямар ч зөвшөөрөлгүй	Хуулийн дагуу нөхөн төлбөрийн асуудал тавьдаг ч хэрэгждэггүй, шүүхэд өгөхөөр маш их чирэгдэлтэй байдаг байна. Үүнээс болж байгаль

	тогтооно.			орчин сүйдэж модгүй, хөрсгүй, гол нь элсгүй болж байна.
10	хуулийн 18.2.2-д Баг, хорооны засаг дарга нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах үүрэгтэй;	Гацуурт тосгонд	Хууль хэрэгжихгүй байна.	Баг, хорооны засаг даргын эрх, үүргийг хуульд ингэж заасан ч тосгоны захиргааны зүгээс дорвитой ажил зохиодоггүй, ганц байгаль орчны байцаагч нь хөөцөлдөөд дийлдэггүй байна.
11.	18.2.4-д нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоох	Гацуурт тосгон	Амьдрал дээр энэ заалтыг хэрэгжүүлдэггүй	албан тушаалтнууд нь ч идэвхи гарган ажилладаггүйгээс хогондоо дарагддаг нь илт харагдаж байна.
12.	27.6-д тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах	Гацуурт тосгон	өчнөөн жилийн өмнө гарсан сонин заалтаар хууль зөрчигчдөд шаардлага тавьдаг	Уг заалтыг 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмэгдсэнийг байгаль орчны улсын байцаагч нь уншиж, судлаагүй, мэддэггүй байна.

“Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн хүрээнд газар ашиглалтын үндсэн чиглэлүүдээр хийгдсэн судалгаа мониторингийн дүнтэй холбогдуулан гаргасан дүгнэлт, санал

№	Анхаарал татсан асуудлууд	Дүгнэлт	Санал, зөвлөмж	тайлбар
Нэг. Хот, суурины газар ашиглалт /хуудас 4-10-аас үзнэ үү/				
1.	Хотын шугам сүжээнд холбогдсон буюу холбогдохоор төлөвлөсөн газрыг нийслэлийн засаг дарга, шугам сүжээнд холбогдоогүй газрыг дүүргийн засаг дарга шийдвэрлэж олгодог нь буруу байна.	Хуулинд ингэж заасан нь газрын сангийн удирдлага алдагдахад хүргэсэн.	Газрын харилцааны хүрээнд холбогдох бүх хууль, журам, тогтоолуудыг дахин шинэчлэж, боловсронгуй болгох	Нийслэлийн газрын алба болон дүүргийн газрын албаны үүрэг давхцаж байгааг дахин нягталж, тодорхой болгох шаардлагатай байна.
2.	ГЗБЕТ боловсруулах журам	Нийслэл, аймаг,	Хот	Газар олголтыг

	аргачлалгүй, түүнд оролцох мэргэжлийн ба салбарын байгууллагуудын эрх үүргийг нарийн хуульчлаагүй байгаа нь ажил удаашрах, чирэгдэл гарах шалтгаан болж байна.	сум, дүүргийн тухайн жилийн ГЗБТ-г мэргэжлийн түвшинд боловсруулах эрх зүйн арга замыг нарийвчлан тогтоож хэрэгжүүлэх	байгуулалтын болон ГЗБЕТ, тухайн жилийн ГЗБТ-г шаардлагын хэмжээнд боловсруулж, олон нийтэд ил тод болгох	зөвхөн дүүргийн газрын алба хийвэл уг ажил шуурхай, чирэгдэл багатай явагдаж, ард иргэдийн бухимдал арилна гэж үзэж байна.
3.	Хотын газар ашиглалтын гол алдаа дутагдал нь удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаагаар холбоотой байна.	Газрын асуудал эрхэлсэн байгууллагуудын тогтолцоо буруу гэж үзэж байна.	Орон нутгийн түвшинд газрын албаны тогтолцоо, ажил үүргийн хуваарийг шинэчлэн тогтоох	Газар ашиглалтын харилцааг эрхлэн явуулж буй байгууллагуудын хоорондын зөрчлийг илрүүлж, хариуцлага хүлээлгэдэг байгууллагатай болгох хэрэгтэй.
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт/ хуудас 10-15/				
1.	Байгаль хамгаалах асуудал нь үндэсний аюулгүй байдлын хэмжээнд яригдах ёстой ч энэ талаар зохиосон ажил нь хуулийн хэрэгжилтийг хангахгүй байна.	Байгаль хамгаалах ялангуяа ТХГН-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Засгийн газар шаардлагын хэмжээнд хүрч ажиллахгүй байна.	ТХГН-ийн тухай асуудлыг Засгийн газрын мэдлээс гаргаж, ҮАБЗ-ийн мэдэлд шилжүүлэх.	Ингэснээр уг зорилт үндэсний хэмжээнд хэрэгжих бөгөөд тухайн үеийн засгийн газрын төсвийн цоорхойг бөглөх явцуу үйл ажиллагаа байхаа болих юм.
2.	ТХГН-ийн хууль болон газрын хуулийн зүйл заалт нь бодит амьдрал дээр зөрчилддөг тул	ТХГН-т хамаарагдах газрын асуудлыг тухайн хуулиар шийдэх шаардлагатай	ТХГН-ийн хуульд өөрчлөлт оруулж, газрын харилцааны асуудлыг зохицуулах	Энэ асуудлыг шийдсэнээр ТХГН-ийн газар ашиглалтад гарах маргааныг арилгаж, хууль хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

3.	ТХГН-д аялал жуулчлалыг эрхлэн явуулах талаар Хуульд тодорхой зүйл заалт оруулж өгөх шаардлагатай байна.	Энэ талаар тодорхой заалт байхгүйгээс аялал жуулчлал эрхлэхэд хуультай зөрчилдсөн хүндрэлүүд гардаг	Хуульд аялал жуулчлал эрхлэх талаар тодорхой зүйл, заалтаар нэмэлт оруулж өгөх	Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад шаардагдах дэд бүтэцтэй холбоотой асуудлууд нь ТХГН-ийн хуулиар хориотой байдаг учир хуульд оруулж өгөх хэрэгтэй юм.
4.	ТХГН-т гарсан зөрчлийн арга хэмжээний торгууль нь бага, улсын байцаагч нарын эрх мэдэл дутмагаас байна.	Үүнээс болоод хууль зөрчигчдөд авсан арга хэмжээ үр дүнгээ өгөхгүй, тэдэнд хууль үйлчлэхгүй байна.	Зөрчлийн арга хэмжээний торгууль, төлбөр болон байцаагч нарын эрхийг нэмэгдүүлэх	Ингэснээр зөрчил багасаж, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага өндөржинө.
5.	ТХГН-ийн орчны бүсэд Сум, дүүргийн засаг дарга болон хамгаалалтын захиргааны дарга нар газар ашиглах зөвшөөрөл олгож хууль зөрчиж байна.	газар ашиглах хууль бус зөвшөөрөл олгодгийг зогсоох шаардлагатай	Энэ талаар тусгай тогтоол, журмыг гаргаж мөрдүүлэх	Хуулийн гадуур зөвшөөрлийг дур мэдэн олгодог үйл ажиллагааг таслан зогсоож, Хуулийн хэрэгжилт сайжирна.
7.	БОЯ, ГУУУЯ зэрэг Эрх бүхий байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр зөвшөөрөл олгодог байдал газар авч байна.	ТХГН-ийн хуулийн заалтыг хууль хэрэгжүүлэх үүрэгтэй эрх бүхий байгууллагууд зөрчиж байна.	Энэ талаар хуулинд нэмэлт заалт оруулах буюу тусгай журмаар зохицуулах шаардлагатай	ТХГН-т хориглосон үйл ажиллагааны чиглэлээр зөвшөөрөл олгодгийг зогсоох ач холбогдолтой
8.	Зарим газарт байгаль орчны даац хэтэрч, байгалийн унаган төрх алдагдахад хүрч байна.	Энэ нь байгаль орчны даацад тохируулан үйл ажиллагаа явуулах нь зүйтэйг харуулж байна.	Эдгээр газруудад дахин үнэлгээ хийж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах	байгаль орчныг хамгаалах, унаган төрхийг хадгалах арга хэмжээ авах хэрэгтэй
9.	ТХГН-ийн талаар удирдах байгууллагаас гарч буй тогтоол, журмууд нууц байдаг нь бодит байдал	ТХГН-ийн талаархи тогтоол, журмыг ард иргэд мэдэхгүй байгаа тул хууль	ТХГН-ийн талаар гарч буй шийдвэрийг олон нийтэд ил тод	Энэ талаар эрх мэдэл бүхий байгууллага болон орон нутгийн

	дээр харагдаж байна.	хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байна.	болгох	удирдлага тодорхой ажил зохиох нь зүйтэй байна.
10.	Орчны бүсэд амьдардаг ард иргэд байгалийн дагалт баялаг ашиглах эрх нь хуулиар хориотой учир малын ашиг шимээс өөр орлогогүй, амьжиргаагаа дээшлүүлэх боломж нь хаалттай байгаад бухимдаж байна.	Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн менежментийг орон нутагт тулгуурлан хөгжүүлэх	Орчны бүсийн тухай хуульд ард иргэдийн амьжиргааг дэмжих талаар нэмэлт өөрчлөлт оруулах	Малчид, иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх нь зүйтэй.
3. Бэлчээрийн газар ашиглалт /хуудас15-22/				
1.	Хэсэг бүлэг малчид нь гэрээгээр бэлчээр нутгаа эзэмшиж, өөрийн эзэмшлийн бэлчээр нутгаа сэлгээтэй ашиглах, сайжруулалт хийж хөрөнгө оруулах сонирхолтой байвч хуулийн заалттай зөрчилддөг байна.	Газрын тухай хуулийн 3.1.3-д заасан ... өөрийн мэдэлд байлгах “ гэсэн заалт хэрэгжихгүй болж байна.	Хуулийн 52.2 дахь заалтыг “сумын засаг дарга бэлчээрийн газрыг малчдын бүлэгт, хамтлагт сум, багийн өөрөө удирдах ёсны байгууллагын албан ёсны санал шийдвэрийг үндэслэн болзол гэрээний дагуу эзэмшүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна” гэж өөрчлөх.	Хуулийн 52.2-д заасны дагуу ... “ашиглуулж байна” гэж хуульчилсан нь сумын засаг дарга бэлчээр ашиглах гэрээг хийж болно, хийхгүй байж ч болно гэсэн утга агуулж, гэрээг хийхгүй байгаагаас бэлчээр нутаг булаацалдах, хэн дуртай нь бусдын нутагт дураараа орох зөрчлийг бий болгож байгаа юм.
2.	Улирлын сэлгээтэйгээр отор нүүдэл хийж, бэлчээр ашигладаг сумдад нэг багийн малчид нь нөгөө багийнхаа нутаг дээгүүр зайлшгүй дайран өнгөрөх шаардлага гардаг бөгөөд бусдын бэлчээрт хэт удаан	Тухайн сумын ИТХ нь отор нүүдэл хийж буй малчид хаагуур явж өнгөрөх, ямар хугацаагаар нэг суурин дээр байх зэргийг нарийвчлан	хуулийн 48-р зүйлд “бэлчээрийн газрыг дайран өнгөрөхдөө тухайн сумын ИТХ-аар баталсан журмыг баримтална” гэж	Журам гаргаж мөрдсөнөөр бэлчээрийг хамгаалах зорилт хэрэгжиж, малчдын хооронд гардаг маргаан шийдэгдэж,

	байж малаа бэлчээх, өвөлжөө хаваржааг нь эвдэж сүйтгэх, газар нутгийн аль сортой бэлчээрийг нь ашиглаж талхлах зэрэг зөрчил гардаг	тогтоосон журам боловсруулсан байх шаардлагатай	оруулах.	бэлчээрийн талхагдал багасах юм.
3.	Хуулинд бэлчээрийг ашиглаж болно гэж заасан нь хугацааны хувьд богино байгаагаас гадна түр зуур ашиглана гэсэн утгатай байна.	бэлчээрийг тухайн үедээ л ашиглаад өнгөрөх сонирхол давамгайлж, хөрөнгө оруулах сонирхол бага байдаг	хуулийн 52.5-д ... “тодорхой болзол гэрээний дагуу ашиглаж болно” гэдгийг “тодорхой болзол гэрээний дагуу эзэмшүүлнэ” гэж өөрчлөх.	Учир нь өөрийн эзэмшилд байгаа нөхцөлд хөрөнгө оруулалтыг газартаа оруулах сонирхол төрнө. Эзэмших эрхийн гэрчилгээгээ банкны барьцаанд тавих нөхцөл бүрдэнэ.
4.	Байгалийн гамшиг тулгарсан үед өөр аймаг, сумын нутагт орох шаардлага гардаг бөгөөд энэ үед малчид ихэвчлэн аман гэрээ, тоохиролцоо хийж зохицдог байна.	Энэ талаар хуулинд тодорхой зүйл, заалт байдаггүйгээс цаг агаар хүндэрсэн үед өөр аймаг сумын нутагт отор нүүдэл хийхдээ ямарч удирдлагагүй, урсгалаар зохицуулдаг байна.	хуулийн 52.8-д ... Байгалын гамшиг гэнэтийн аюулын улмаас өөр аймаг сумдын нутагт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны засаг дарга нар гурвалсан гэрээ хийнэ гэсэн заалт оруулах.	гэрээ хийж, тусгай болзол нөхцлийг нь заахгүй бол, нөгөө талаас газрын төлбөр /бэлчээр ашигласан/ нэхэх, гэрээнд заагаагүй бусад нөхцлийг шаардах зэргээр маргаан гарч болзошгүй юм.
5.	хуулийн 44 дүгээр зүйл: “газар ашиглах” гэсэн бүлэгт дан ганц гадаадын иргэдийн эрх зүйн зохицуулалтын талаар орсон	бэлчээр, хадлан, тариалангийн болон бусад газрын ашиглалтын талаар /27-43 дугаар зүйл/ тодорхой заалт байхгүй байна.	Ашигт малтмалын тухай /лицензийн асуудал/ болон ТХГН-ийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль, Үндсэн хуулийн заалтуудын зөрүүг арилгах арга хэмжээ авах	Энэ олон хуулиуд хоорондоо зөрчилдөөнтэй байгаа учраас газар нутгийн маргаан их гардаг байна.

6.	одоогийн байдлаар бэлчээрийг орон нутгийн хэмжээнд сайжруулах хөрөнгө байхгүй байна. улсын төсвөөс бэлчээрийн нөхөн сэргээлт явуулдаг гэх боловч энэ нь гол байршлаа олохгүй, ашиг багатай газруудад хөрөнгө зарцуулж байна.	Бэлчээрийг сайжруулах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож, түүнийг гол шаардлагатай газруудад зөв зохистой зарцуулах хэрэгтэй	Бэлчээрийн тухай тусгай хууль боловсруулж бэлчээрийн газрыг төлбөртэй болгох, бэлчээрийг нөхөн сэргээхэд зориулсан тусгай сан байгуулах.	Иймд бэлчээрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын статусыг тодорхой болгох шаардлагатай юм.
7.	Хөдөө орон нутгаас малтай иргэд хотод орж ирэх нь ихсэж байгаа өнөөгийн нөхцөлд түүнийг зохицуулах арга хэмжээ шаардагдаж байна.	үүнийг төрийн зүгээс зохицуулах бодлого боловсруулах.	Газар тариалан МАА-г хослуулан, эрчимжсэн МАА-г хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.	тариалангийн газрыг иргэдэд үнэгүй өмчлүүлж орчных нь бэлчээрийг удаан хугацаагаар эзэмшүүлэх хэрэгтэй байна.
8.	Бэлчээрийн менежментийн чиглэлээр олон төсөл хэрэгжиж байгаа боловч хоорондоо уялдаа холбоогүй, үр өгөөжгүй ажил хийгдэж байна.	хэрэгжиж буй олон улсын төслүүдийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна	Үүний тулд уг төслүүдийг нэгтгэн зангидаж хэрэгжүүлэх, төслийн үр ашгийг дүгнэж ажиллах	Эдгээр төсөл хэрэгжсэний үр дүнд бэлчээрийн менежмент сайжирч тодорхой үр дүнд хүрсэн байх ёстой.
9.	хуулийн 53.2-д “Сум дүүргийн засаг дарга, хадлан авах бололцоотой талбайг жил бүр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулахаар баг хорооны ИТХ-ын саналыг хуваарилж, түүний хэрэгжилтийг зохион байгуулна” гэж заасан байдаг	Энэ нь жил бүр ашиглагч нар нь солигдоно гэсэн санааг агуулж байгаа учир түр ашиглаад өнгөрөх сонирхол той болохоос эзэмшиж, хөрөнгө оруулах сонирхол байдаггүй байна.	Хуулинд хадлангийн талбайг гэрээгээр эзэмшүүлэх, ашиглуулах гэсэн заалт оруулах.	Энэ нь хадлангийн талбайг хашиж хамгаалах, арчлах, хөрөнгө оруулалт хийж сайжруулах сонирхлыг бууруулдаг байна.
10	Тариалангийн талбайн өмчлөлийн асуудал нэг мөр шийдэгдээгүй маргаантай байгаа нь одоо ашиглаж буй талбайгаа яаж тариаланчид	Тариалангийн талбайг өмчлөх асуудлыг тодруулах шаардлагатай	одоо эзэмшиж байгаа талбайг он удаан жил ашиглаж ирсэн тариаланчдад нь	Энэ асуудлыг шийдсэнээр олон жил ажилласан тариаланчдад талбай нь үнэ

	цаашид хэрхэн ашиглах талаар тодорхойгүй байдалд хүргэж байна.		давуу эрхээр, үнэ төлбөргүй өмчлүүлэх талаар бодлогын хэмжээнд асуудал боловсруулах.	төлбөргүй шилжиж, цаашид мэргэжсэн тариаланчидтай болоход дөхөм болох юм.
Дөрөв. Уул уурхайн газар ашиглалт /хуудас 23-25/				
1.	Алтны олборлолтын хэмжээ ихсэж байгаа ч нөхөн сэргээлт хийхдээ газрыг буцааж булах төдийхнөөр оромдож, бага хэмжээний хөрөнгө зарцуулж, байгалийн биологийн нөхөн сэргээлтэд төдийлөн анхаарахгүй байгаа нь цаашид уг газрыг ХАА-н зориулалтаар ашиглах боломжийг бууруулж байна.	Газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх, төр захиргаа, орон нутгийн байгууллагаас уг ажилд тавих хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай	2000 онд батлагдсан алтны уурхайн нөхөн сэргээлтийн стандартыг мөрдөж ажиллах, алт олборлолтонд орчин үеийн технологийг нэвтрүүлэх	Алт олборлох үйл ажиллагаа нь нэг талаараа Монгол орны эдийн засагт чухал хэрэгцээтэй хэдий ч нөгөө талаар байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа нь сүүлийн 10 гаруй жилийн байдлаас харагдаж байна.
2.	Одоо хийгдэж байгаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүд нь зөвхөн мөнгө олохын төлөө ор нэрийн төдий хийгдэж, нөхөн сэргээлтийн төслийн үр дүн гарахгүй байна.	Ашигт малтмал ашигласан газрын нөхөн сэргээлт болон үнэлгээний чиглэлээр хэрэгжиж буй төслүүдэд тавих хяналтыг нарийсгаж, үр дүнг тухай бүр тооцож дүгнэх явдал хангалтгүй байна.	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нарийвчилсан үнэлгээгээр тооцож, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг үр дүнтэй авч хэрэгжүүлэх	Ийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасаж, төслийн үр дүн өгөөжтэй болно.
3.	Заамар сумын иргэдийн дийлэнх нь алт олборлолтыг буруу гэж үзээгүй бөгөөд зөвхөн уг ажлын зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай гэсэн саналыг тавьж байна.	Алт олборлох үйл ажиллагаанд Төрөөс болон орон нутгийн зүгээс тавих хяналт шалгалт, шаардлагыг сайжруулах нь зүйтэй .	Нэгэнт ачаалал нь ихэдчихээд байгаа газарт дахин лиценз нэмж олгохгүй байх, нөхөн сэргээлтийг огт хийдэггүй аж ахуйн нэгжүүдийг дараа жил нь тухайн газарт дахин	Алтны уурхайнууд хаягдалгүй технологи ашиглаж, нөхөн сэргээлтийг журмын дагуу хийсэн бол хууль бусаар алт олборлогчид тэдний нөхөн сэргээлт хийсэн

			ажиллуулдаг зөрчлийг таслан зогсоох	талбай руу орох боломжгүй юм.
<i>Тав. Тариалангийн талбайн ашиглалт /хуудас 26-29/</i>				
1.	<i>Тариаланчид нь өгөгдсөн газрын талаар зарцуулах эрхгүйгээс амьжиргаагаа дээшлүүлэх боломжгүй байна.</i>	<i>Тариаланчдад эзэмшлийн газрыг нь өмчлүүлэх талаар гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, цаашид эрчимжүүлэх</i>	<i>Тариаланчид өрхөөнд нь, газрын дагуу эрхээр, эрх зүйн хэрэгээр</i>	<i>Тариалангийнхаа газрыг өмчилж авбал нэгэнт оруулсан хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэж, өөрийн гэсэн өмчдөө хөрөнгө оруулалт хийх сонирхол нь нэмэгдэнэ.</i>
2.	<i>Тариалангийн талбай эзэмшиж буй тариаланч иргэд хөрөнгө мөнгөгүй, тоног төхөөрөмжгүй учраас талбайгаа бүрэн ашиглаж үр шимийг хүртэх боломжгүй байна.</i>	<i>Тариаланчид нь өмчлүүлэх талаар гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, цаашид эрчимжүүлэх</i>	<i>Тариаланчид өрхөөнд нь, газрын дагуу эрхээр, эрх зүйн хэрэгээр</i>	<i>Эдгээр арга хэмжээний үр дүнд тариалангийн талбайн ашиглалт үржил шим нь сайжирч, эзэнжиж, тариаланчид хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх боломжтой болно.</i>
3.	<i>Тариалангийн талбайн ашиглалт хангалтгүй байна.</i>	<i>Нэг тариаланч өрхөд өмчлүүлэх газрын тохиромжтой хэмжээг тогтоогоогүй, талбайтай өрх бүр тариалан эрхлэх боломжгүй зэргээс талбайгаа бүрэн ашиглаж чадахгүй,</i>	<i>Тариаланчид өрхөөнд нь, газрын дагуу эрхээр, эрх зүйн хэрэгээр</i>	<i>Ингэснээр талбайн хэмжээний маргаан гарахгүй болж, өрх бүр өөрийн газар дээрээ боломжтой аргаар тариалан эрхлэх боломж бүрдэнэ.</i>

		их хэмжээний газар атаршиж байна.	өгөх	
Зургаа. Хууль эрхзүйн дүгнэлт /хуудас 29-31/				
1.	Газрын харилцаанаас үүссэн маргаантай хэргийг шүүх хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагаа сүүлийн 2 жилд өсөх хандлагатай нь байсан нь Газрын тухай хууль, МУ-ын иргэнд Газар өмчлүүлэх тухай хууль батлагдан мөрдөгдөх болсонтой холбоотой юм.	2004.6.1-нээс “Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хууль үйлчилж эхэлсэнээр газрын харилцаанаас үүссэн маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх болсонтой уялдан шүүхээс маргаантай хэргийг шийдвэрлэх тоо буурсан байна.	Цаашид захиргааны хэргийн шүүхийн зүгээс газрын харилцаатай холбогдон гарсан маргааныг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх шардлагатай	
2.	Зүүн бүсэд өдөр тутам судалгааны явцад ажиглагдлаа.	Зүүн бүсэд өдөр тутам судалгааны явцад ажиглагдлаа.	Газар өмчлүүлэх тухай хуулийн талаар холбогдох байгууллагууд иргэдэд мэдлэг олгох сурталчилгааг хороо, дүүргийн хэмжээнд хийх нь зүйтэй байна.	Зүүн бүсэд өдөр тутам судалгааны явцад ажиглагдлаа.
3.	Баянгол дүүргийн хэмжээнд өдөр тутам судалгааны явцад ажиглагдлаа.	Энэ нь шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль үйлчилж эхэлсэнээр газрын харилцаанаас үүссэн маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх болсонтой уялдан шүүхээс маргаантай хэргийг шийдвэрлэх тоо буурсан байна.	Газар өмчлүүлэх тухай хуулийн талаар холбогдох байгууллагууд иргэдэд мэдлэг олгох сурталчилгааг хороо, дүүргийн хэмжээнд хийх нь зүйтэй байна.	Зүүн бүсэд өдөр тутам судалгааны явцад ажиглагдлаа.

	<p>байгууллагад сүүлийн жилүүдэд олноор ирэх болсон байна.</p>	<p>эзмших маргаан ихэссэнтэй холбоотой гэж үзэж байна.</p>	<p>□□□□□□□□ □□□□□□ □□□□□□□□□□х ажлыг сайжруулах</p>	<p>□□□□□□□□ □□□□□□□□□□ □□□□□□□□ □□□□□□□□□□□□ □.</p>
--	--	--	--	---

